

ЗҮҮНГАР ДАХЬ ЧИНГИЙН АЯН ДАЙН БА САРНИСАН ОЙРАДУУДЫГ ИЛИД НУТАГЛУУЛСАН НЬ

Б.Леви

Товч агуулга: Зүүнгарыг эзэлсэний дараа тэнд суусан Манжийн жанжсин, сайд нарын Тэнгэрийн тэтгэсэн хаанд өргөсөн нууц албан айлтгалууд БНХАУ-ын Түүхийн нэгдүгээр архивт нээлттэй хадгалагдаж байвч орчин үеийн судлаачид төдийлөн ашиглаагүй байсаар ирлээ. Иймд тус өгүүлэлд зохиогчийн сүүлийн үед олж үзсэн манж хэлээрх архивын баримтыг ашиглан, Зүүнгарын мөхлийн дараа газар газарт сарнисан ойрадууд хэрхэн Манж Чин улсын хамгаалал дор уугуул нутагтаа суурьшсан тухай өгүүлнэ.

Түлхүүр үг: Зүүнгарын мөхөл, махчин, сарнисан ойрадууд, Ил

Удиртгал

XVII зууны сүүлээс эхлэн монголчуудтай соёлын хувьд гүнзгий харилцаатай ойрад* (зохиогч манж хэлний *ület* хэмээх үгийг *ойрад* хэмээн орчуулж хэрэглэжээ. Бид манж эхийг даган эшилсэн баримтанд өөлд хэмээн буулгав.—орч.) аймгуудын холбоо Зүүнгарын улс нь Чин улсын тэргүүн дайсан болжээ. Чин улс Зүүнгартай хэдэнтээ дайтаж эцсийн эцэст 1758 онд бүрэн ялсан бөгөөд Тэнгэрийн тэтгэсэн (1736-1795) хааны хувьд энэ сүүлчийн ялалт нь түүний өвгө эцэг Энх-Амгалангийн эхлүүлсэн Чин улсын баруун хойд хязгаар дахь нүүдэлчдийн сүүлчийн гүрнийг дарж авах гэсэн чармайлтын эцсийн үр дүн байв. Зүүнгарыг мөхөөсөн энэ ялалтыг дурсгахын тулд Чингийн засаг үргэлжилсэн үгийн түүх, баримтын эмхтгэл, яруу найргийн цомог, булш, хөшөөний бичээс бас зурагт хуудасуудыг зохиолгожээ. Зүүнгарыг эзлэн захирсан эхний жилүүдийн тухай хувийн дурсамжууд ч бас бидэнд уламжлан ирсэн байна. Гэвч Зүүнгарыг колоничилсон эхний жилүүдийн эдгээр хятад хэлээрх баримтууд нь тус нутгийн ойрад, хасаг нарт бараг анхаарал хандуулсангүй. Ялагчид түүхийг бичдэг жамаар, Чингийн албан түүхчид Зүүнгарыг эзлэн колоничилсон үйл явцыг болох л ёстой зүйл байсан гэж бичсээр иржээ. Ялагдсан ойрадууд энэ түүхэнд бараг дурдагдахгүй, хасаг нар Чинд хэрэгтэй бараа таваарыг нийлүүлдэг тулдаа хаа нэг дурсагдагддаг. Ихэвчлэн эдгээр ХҮIII зууны хятад хэлээрх эх сурвалжийг үндэслэн XIX зууны хятад хэлээрх зохиолуудаас эхлээд XXI зууны англи хэлээр бичсэн

судалгааны ажлууд хүртэл бараг бүгд ХҮШ зууны Чингийн албан түүхчидийн Зүүнгарыг эзлэн дагуулсан үзлийг давтан дамжуулжээ.

Гэтэл энэ үеийн анхдагч эх сурвалж болох, Зүүнгарт дарангуй суусан эзэнт гүрний төлөөлөгчдийн Тэнгэрийн тэтгэсэн хаанд өргөсөн нууц албан айлтгалууд Зүүнгарыг эзлэн захирсан эхний жилүүдийн байдлыг их л өөрөөр бидэнд харуулж байна. Энэ баримтуудаас үзэхүл ойрад, хасгууд Чингийн засаг захиргааны гол асуудал байсан нь мэдэгдэнэ. Эдгээр баримтын ихэнх нь Чин улсын засаг барьсан манж нарын өөрсдийнх нь, хятад хэлтэй огт холбоогүй, алтай язгуурын манж хэлээр бичигдсэн байгаа юм. Хэдийгээр энэ баримтууд БНХАУ-ын Түүхийн нэгдүгээр архивт нээлттэй хадгалагдаж байвч орчин үеийн судлаачид төдийлөн ашиглаагүй байсаар ирлээ.

Эдгээр манж хэлээрх баримт дээр үндэслэн зохиогч Чин төвтэй түүхчидийн үзэл баримтлалын эсрэгээр тус бүс нутгийн уугуул ойрад, хасаг ард түмнийг үйл явдлын голд байрлуулан судалж байна. Энэ өгүүлэл нь миний докторын зохиолын хоёрдугаар бүлгийн товчлол бөгөөд өөрийн судалгааны үр дүнг бичин гаргахаар хичээсэн эхний оролдлого юм. Энэ бүлэгт, юуны өмнө Зүүнгарын ард түмнийг эсрэг явуулсан Чингийн хядлагыг давуулж тооцож байсан гэж үзэх бөгөөд үүний хажуугаар бид Чингийн цэргийн Зүүнгарын эсрэг явуулсан хядлагыг үгүйсгээгүй ч маш их ойрадын дүрвэгчид Чингийн талаас хамгааллыг олж Зүүнгарт буцан суурьшсан тухай өгүүлнэ. Түүнчлэн Чингийн түрэмгийллээс өмнөх ойрад болон хасагийн хооронд зуун зуунаар үргэлжилсэн харилцаа нь Зүүнгарыг захирсан Чингийн эхний жилүүдийг ойлгох гол түлхүүр байсныг тодорхойлно. Ойрад хасагийн хоорондох нэгэн зууны дайн самуун эв найрамдлын харилцаа нь Чинд эзлэгдсэнээс хойш манж нарт уламжлагдаж Чингийнхэн энэ урт удаан хугацааны тэмцлийн голд нь ороод явчихжээ. Ойрад-Хасагийн хоорондох харилцааг зохицуулах нь Зүүнгарыг захирч байсан Чингийн захиргааны гол төвлөрсөн асуудал болсон юм.

1. Махчинг хядсан нь: Зүүнгарын босогчдын эсрэг Чингийн явуулсан залхаан цээрлүүлэх аян дайн

1758 он гэхэд Чин улс Зүүнгарын ямар нэгэн зохион байгуулалттай эсэргүүцэл үзүүлэх чадлыг нугалж авчээ. Гэвч энэ нь Зүүнгарынхны эсрэг явуулах Чин улсын цэргийн аян дайн ингээд зогссон гэсэн үг биш байлаа. 1757 оноос эхлэн 1761 он хүртэл Чингийн цэрэг уугуул нутгаасаа босч Зүүнгарын уулсын өндөр уулын бэлчээр нутаг өөд зугтан нуугдсан зүүнгарын босогчдыг мөрдөн хөөж хядан устгасан харгис аян дайн явуулсан юм. Эдгээр Зүүнгарын дүрвэгчдээс бага хэсэг нь л малтай байж, малгүй нь зэрлэг ан гөрөөс авлаж амь

зуусан бөгөөд үлдсэн нь дээрэм тонуул эрхэлжээ¹. Чингийн тал тэдгээр Зүүнгарын дүрвэгчдийг бүгдийг нь “махчин” (манж mahacin)² хэмээн нэрлэж байв. Залхаан цээрлүүлэх аян ихэд харгис байсан бөгөөд Чингийн цэргийн дарга нар хаанд өргөсөн айлтгалууддаа нэг удаагийн байлдаанд хэдэн махчин “дээрэмчид”-ийг устгаснаа бахархалтайгаар мэдэгдэж байв. Энэ хядлага нь мал булааж Чингийн цэргийг довтолсон ойрадуудыг төдийгүй тэдний эхнэр хүүхдийг ч тойрсонгүй, бүгдийг нь толгой дараалан хядаж байжээ. Или орчимд махчин нарын эсрэг явуулсан цэргийн ажиллагааны тухай айлтгал эдгээр аян дайны харгис хүчирхийллийг тодорхой харуулна. Чингийн салаа цэрэг Баран нэртэй Зүүнгарын босогчийг барьж аваад эрүүдэж Чихэр Хад хэмээх ууланд түүний олон нөхөд нуугдаж байгааг мэдэж авчээ. Тэгээд тэр Баранг эрүүдэж нөхдийнхөө нуугдаж байгаа газар зам заан аваачихыг тулгав.

“Барангаар газарчлуулан хоёр өдөр явав. Чихир хаданд хүрч үзвээс, уул маш их, цөм чулуу давхарлаж эгц өндөр. Ганц орж гарах нэг амтай аж. Мориор өгсвөөс болохгүй тул цэргийн агтыг аргамжиж шөнөөр явгалан өндөр ууланд өгсөв... Хулгай нар явганаар буруулан чадахгүй тул цөм дарагдав. Батай Бало нар нэг хулгайг амьд барив. Бусад эр эм хүүхдийг цөм алав. Уулнаас бууж, Баран, Төмөр нэрт хулгайг нэг нэгээр ам нийлүүлэн бас махчин хулгай бий үгүй сонссон нь бүхүй үгүй явдлыг хянан асууваас өчсөн нь, “Манай суусан уулын орчин тойрон огт өөр зүйлийн махчин хулгай үгүй. Өнгөрсөн оноос нааш энэ Чихир хаданд шивээлэн суусан хүртэл огт махчин нарыг мэдсэнгүй. Цас их ер гөрөөс олдохгүйд үхэхэд хүрэн, эсхүл өртөөнд бүхүй эсхүл цэрэг таарах болвоос морь хулгайлан авсугай хэмээн явсан. Гэнэт тантай тааралдсан” хэмээн өчмөй. Үүнд та нар орчмын махчин нарын явах газар мэдсэнгүй байвч энд тэнд зайлсан, буруулсан үүрлэсэн хулгай байваас та яахан сонсохгүй аж. Хурдан өчихгүй болвоос махыг огтчиж ална хэмээн өвтгөн эрүү тулган асууваас, огт сонссон

¹ Махчин нарын өдөр тутмын амьдралын тухай Миншүй, ТТ 28.10.22. MaLFZZ 2058-020; 069-0417 –д үзмүү.

² Махчин гэдэг үгийн гарал тодорхой бус, хамгийн анх Жао Хуйн Тэнгэрийн тэтгэсний 20-р онд өргөсөн айлтгалд гардаг. Жао Хуй энэ үгийг Амарсанаагийн хамт уул оод зугтан ан агнаж суусан ойрадуудыг нэрлэхэд хэрэглэсэн байдаг. “(Тарвагатай орчимын) Барлаг уулын орчим газар махчин хулгай нар буй эсэхийг тодорхой мэдэх аргагүй байна... саявтар бид Амарсанааг дагалдагсдын нутгийг довтлов. Амарсанааг хэдэн хүн аваад оргосон эсхүл энэ хязгаар нутагт орж зэрлэг гөрөөс агнан нуугдан сууж буйг мэдэхгүй байна. Би Айлунгад хоёр зуун цэрэг өгч Барлаг орчим нуугдан сууж буй махчин хулгай нарыг эрэн хядаж арилгахыг тушаав.” Жао Хуй, ТТ 22-06-18. MaLFZZ 1668-011; 047-0756.

зуусан бөгөөд үлдсэн нь дээрэм тонуул эрхэлжээ¹. Чингийн тал тэдгээр Зүүнгарын дүрвэгчдийг бүгдийг нь “махчин” (манж mahacin)² хэмээн нэрлэж байв. Залхаан цээрлүүлэх аян ихэд харгис байсан бөгөөд Чингийн цэргийн дарга нар хаанд өргөсөн айлтгалууддаа нэг удаагийн байлдаанд хэдэн махчин “дээрэмчид”-ийг устгаснаа бахархалтайгаар мэдэгдэж байв. Энэ хядлага нь мал булааж Чингийн цэргийг довтолсон ойрадуудыг төдийгүй тэдний эхнэр хүүхдийг ч тойрсонгүй, бүгдийг нь толгой дараалан хядаж байжээ. Или орчимд махчин нарын эсрэг явуулсан цэргийн ажиллагааны тухай айлтгал эдгээр аян дайны харгис хүчирхийллийг тодорхой харуулна. Чингийн салаа цэрэг Баран нэртэй Зүүнгарын босогчийг барьж аваад эрүүдэж Чихэр Хад хэмээх ууланд түүний олон нөхөд нуугдаж байгааг мэдэж авчээ. Тэгээд тэр Баранг эрүүдэж нөхдийнхөө нуугдаж байгаа газар зам заан аваачихыг тулгав.

“Барангаар газарчлуулан хоёр өдөр явав. Чихир хаданд хүрч үзвээс, уул маш их, цөм чулуу давхарлаж эгц өндөр. Ганц орж гарах нэг амтай аж. Мориор өгсвөөс болохгүй тул цэргийн агтыг аргамжиж шөнөөр явгалан өндөр ууланд өгсөв... Хулгай нар явганаар буруулан чадахгүй тул цөм дарагдав. Батай Бало нар нэг хулгайг амьд барив. Бусад эр эм хүүхдийг цөм алав. Уулнаас бууж, Баран, Төмөр нэрт хулгайг нэг нэгээр ам нийлүүлэн бас махчин хулгай бий үгүй сонссон нь бүхүй үгүй явдлыг хянан асууваас өчсөн нь, “Манай суусан уулын орчин тойрон огт өөр зүйлийн махчин хулгай үгүй. Өнгөрсөн оноос нааш энэ Чихир хаданд шивээлэн суусан хүртэл огт махчин нарыг мэдсэнгүй. Цас их ер гөрөөс олдохгүйд үхэхэд хүрэн, эсхүл өртөөнд бүхүй эсхүл цэрэг таарах болвоос морь хулгайлан авсугай хэмээн явсан. Гэнэт тантай тааралдсан” хэмээн өчмой. Үүнд та нар орчмын махчин нарын явах газар мэдсэнгүй байвч энд тэнд зайлсан, буруулсан үүрлэсэн хулгай байваас та яахан сонсохгүй аж. Хурдан өчихгүй болвоос махыг огтчиж ална хэмээн өвтгөн эрүү тулган асууваас, огт сонссон

¹ Махчин нарын өдөр тутмын амьдралын тухай Миншүй, ТТ 28.10.22. MaLFZZ 2058-020; 069-0417 –д үзмүү.

² Махчин гэдэг үгийн гарал тодорхой бус, хамгийн анх Жао Хуйн Тэнгэрийн тэтгэсний 20-р онд өргөсөн айлтгалд гардаг. Жао Хуй энэ үгийг Амарсанаагийн хамт уул оод зугтан ан агнаж суусан ойрадуудыг нэрлэхэд хэрэглэсэн байдаг. “(Тарвагатай орчимын) Барлаг уулын орчим газар махчин хулгай нар буй эсэхийг тодорхой мэдэх аргагүй байна... саявтар бид Амарсанааг дагалдагсдын нутгийг довтлов. Амарсанааг хэдэн хүн аваад оргосон эсхүл энэ хязгаар нутагт орж зэрлэг гөрөөс агнан нуугдан сууж буйг мэдэхгүй байна. Би Айлунгад хоёр зуун цэрэг өгч Барлаг орчим нуугдан сууж буй махчин хулгай нарыг эрэн хядаж арилгахыг тушаав.” Жао Хуй, ТТ 22-06-18. MaLFZZ 1668-011; 047-0756.

мэдсэн нь үгүй хэмээмой. Эднийг эрүүлсэнд нэг хулгай үхсэн, нэг нь элдвээр эрүүдвээс бус өчиг үгүй. Үүнийг даруй цаазлав.³

Энэ айлтгалаас, Чингийн засаг Зүүнгарын “махчин” дүрвэгчдийг хир харгисаар дарж байсныг шууд харж болох байна. Чингийн цэргүүд хүүхэд эмэгтэйчүүдийг хядаж, золгүй олзлогдогсдыг эрүүдэж байгаа дээрх дүр зураг нь ганц нэг тохиолдол бус байв. Үнэн байдал дээр Чингийн цэргүүд 1757 оноос 1761 оны хооронд ууланд олон тооны гэнэтийн довтолгоон явуулж ойрадуудыг хядсан юм. Энэ кампаниудын зорилго нь Чингийн захиргааг идэвхитэй эсэргүүцэн буй Зүүнгарын цэргийг дарахаас илүүтэй ихэнх нь зэвсэгт эсэргүүцэлд идэвхтэй оролцоогүй Зүүнгарын хүмүүсийг залхаан цээрлүүлэх зорилготой байв.

Зүүнгарыг эзэлсэн Чингийн байлдан дагууллын тухай түрүү үеийн судалгаанд энэ үеэр Зүүнгарын эсрэг үйлдсэн Чингийн хүчирхийллийг ихэд тодотгож зарим судлаачид энэ хядлагыг “геноцид”-тэй дүйцэх үйл явдал байсан гэж үзэж байв.⁴ Энэ түүх бас ч худал бус – Чин улс үнэхээр ууланд нуугдан буй *махчин* нарын эсрэг цуст хүчирхийлэл үйлдсэн юм. Энэхүү хялбар нэг талыг барьсан дүрслэл нь илүү адармаатай бодит байдлыг халхалж байгаа бөгөөд үнэндээ Зүүнгарын дүрвэгчдийн нилээд нь хядлагад өртөөгүй бөгөөд тэдний ихэнх хувь нь тэдний удаан жилийн дайсан хасагуудад олзлогдсон байжээ. Энд тэдний тухай эхлээд өгүүлье.

³ [Barang be gajarcilame juwe inenggi yabume. cihir hada de isinafi tuwaci. alin umesi amba. gemu wehei sahabime umesi haksan den. damu dosire tucire emu angga i teile. morin tafaci ojurakū ofi. coohai morin be hūwaitafidobori yafahalame. den alin de tafafi...hūlhasa yafagan bime burulame muterakū ofi. gemu gisabuha. batai. balo seemu hūlha be weihun jafaha. gūwa haha hehe juse be gemu wafi. alin ci wasifi. barang. temur gebungge hūlha beemke emken i angga acabume geli mahacin hūlha bio akū. aici donjihangge bisire akū babe kimcime fonjicijaburengge. meni tehe alin i hanci šurdeme umai gūwa hacin i mahacin hūlha akū. duleke aniya ci ebsi. ere cihirhada de sibeleti tehe erelele umai mahacin sebe sabuhakū. nimanggi amba fuhali gurgu baharakū de. bucere be baime aici giyamun bisire. aici cooha teisulere oci morin hūlhame gaiki seme yabuha gaitai suwende teisulebuheseme yabumbi. ede suwe hanci mahacin se yabure ba sabuhakū bicibe uba tuba jailaha burulaha. tomoho hūlhabici. suwe ainu donjirakū. hūdun jaburakū oci. yali faitame wambi seme. nimebume erun nikebume fonjici. umaidonjiha sahangge akū sembi. ede erulehei emu hūlha bucehe emke be eitereme eruleci gūwa jabun akū. erebe uthaidayabuha.] Yungui, QL23-10-02. MaLFZZ 1721-011; 050-1858.

⁴ Миний бие махчингийн эсрэг аян дайныг “геноцид” гэж үзэхэд эргэлзэж байгаа болно. Энэ өгүүлэлд, зөвхөн Чин улс Зүүнгарыг бүрмөсөн мөхөөсөн 1758 оноос хойших дүрвэгчдийг өгүүлж байгаа бөгөөд их хөл үймээн болохоос өмнө нилээд их тооны ойрадууд Чинд дагаар орсон билээ. Тэднээс нилээд алдартай жишээ гэвэл дорвөдийн нилээд хувийг дагуулан Чинд дагасан Дорвөдийн “гурван Цэрэн” хэмээгдсэн Цэрэн, Цэрэн увш, Цэрэнмөнх гурав билээ.

2. Номгүй улсын нутагт: Чингийн Ойрадын бодлогын эхлэл

Чингийн цэрэг ууланд махчин нарыг хядаж байхад өөр нэг хэсэг Чингийн цэрэг ойрадын нөгөө нэг хэсэг дүрвэгчдэд их л хүлээцтэй сайн хандаж байлаа. Эдгээр ойрадууд “судар номгүй улс” болох хасагуудын гараас зугтан гарч ирсэн чин сүзэгтэй буддистууд байв.

1759 онд Лобжиа хэмээх ойрад эр таван нөхдийн хамт хасаг эздээсээ оргон ирж Чингийн цэрэгт дагаар орсон агаад Зүүнгарыг мөхөхөөс гурван жилийн өмнө хасагууд Бор тал дахь тэдний нутгийг довтолж нутагтаа аваачин боол болгожээ. Байцаахад, Лобжиа ном буруу хасагийн дунд байж чадахаа больж нутгаа санаад босч ирсэн хэмээсэн бөгөөд нэг үдэш Бурханд залбираад Хасагаас оргоё гэж хөгшин эх, ах дүү нартайгаа ярилцжээ. “Алуулах болсон ч шарын шажинтай газар л очиж үхье” хэмээн ярилцаад хасагаас арван зургаан морь хулгайлж, Тарвагатай уулын хойт этгээдээр явж Чингийн цэрэгт хүртэл морьдынхоо заримыг хүнсэнд хэрэглэж иржээ. Энэ дүрвэгчидийг Чингийн цэргийн ахлагч Нусан, тэд нар “шарын шажныг эрж хол замыг туулан ирсэн” тул “өлсгөлөн махчин”-тай адилтгаж болохгүй⁵ хэмээгээд хаанаас эдгээр ойрадуудыг Зүүнгарт суулгах эсхүл Бээжинд илгээж байцаалгах тухай асуулгажээ. Хасагтай муудалцахгүй тул Тэнгэрийн тэтгэсэн хаан “*танай газарт агуулваас хасаг мэдсэн хойно тусгүй. Хүнс өгч нийслэл хотноо илгээ*” гэсэн зарлиг буулгажээ⁶. Тэнгэрийн тэтгэсэн хааны товч зарлиг хасаг ойрад нарын хоорондох удаан жилийн өс хонзогнолыг зохицуулах гэсэн Зүүнгар дахь Чингийн засаглалын гол санаашралыг харуулж байна. Энэ дайсагнал нь Ойрад-Чингийн дайны шууд үр дүр бус, харин бүр Чин улс Зүүнгарыг эзэлж

⁵ Нусан ТТ 24.06.03. MaLFZZ 1771-007.1; 053-2265. Лобжиаг Бээжинд илгээсэн тухай дэлгэрэнгүйг ТТ 24.07.24. MaLFZZ 1818-040; 056-2124. Лобжиа нар Тэнгэрийн тэтгэсний 24 онд шажны учраас дагаар ирсэн ганц бүлэг биш байв. Жишээ нь гурван жилийн өмнө хасагт олзлогдсон Цэгэр хэмээгч өөрийн бол дүү Мажанд “Бид номгүй хасагт байх атугай их улсын цэргийг эрэн одож ах дүүтэйгээ нийлж удаан жарган суусугай хэмээн санамой” [be nomun akū hasak de bisire anggala. amba gurun i cooha be baime genefi. mukūn falga de acafi. entehen jirgame banjiki seme gūnifi.] хэмээн яриад Мажан болон өөр нэг ойрадын хамтаар оргож зургаа хоногийн дараа Чингийн харуулд орж ирэн дагажээ. Цэвдэнжав, ТТ 24.илүү06.16. MaLFZZ 1776-011; 053-3392. Эдгээр сүзэгтэй ойрадууд нилээд их тоогоор ирж байсан бөгөөд 7 жилийн хойно ТТ 31-р онд Агуй бээр хаанд айлтгахдаа: “Илийн газар анхлан өөлд нарыг цуглуулан суулгах цагт, цэрэг хомс, нутаг бас аж төрөхөөр одоогүй болгөө. Хасаг, Бурудаас оргон гарсан өөлд нар бүрэн эзний хишгийг хүртэн бурхан ном бүхий их газарт одож жарган амьдарсугай хэмээх үнэн санаа барьсан тул нэг ч ортосон газаргүй билээ. Эдүгээгийн эрэн гарсан өөлд нарын дотор, сая хүрч ирээд даруй оргосон нь байна...хоёр гурван удаа болов.” [ili i bade fukjin ület sebe bargiyafi tebure fonde. cooha komso. nukte kemuni banjina unde bime. hasak. burut ci ukacafi tucike ület se. yooni ejen i kesi be alime fuchi nomun bisire da bade marifi. jirgame banjiki sere unenggi gūnin jafaha ofi. emke hono ukaka ba akū bihe. te i baime tucike ület sei dorgi. teni isinjime uthai ukakangge bimbime...juwe ilan mudan oho.] Агуй, ТТ 31.04.01. MaLFZZ 2185-003; 077-0043.

⁶ [Suweni bade bibuci hasak saha manggi. tusa akū. kunesun bufi. gemun hecen de benju sehe.] Нусан, ТТ 24.06.03. MaLFZZ 1771-007.1; 053-2265.

ямар нэг хяналт тогтоохоос ч өмнө үүсч олон арван жилийн турш дэврэн нэмэгдсээр ирсэн юм. 1723-1726 онд Цэвээнравданы тэргүүлсэн ойрадын цэрэг Хасагийн тал нутагт цөмрөн орж хасагуудыг баруун тийш шахан хөөж олон хүний амь насыг сүйтгэжээ. Энэ дайныг хасагийн аман зохиолд “хөл нүцгэн дүрвэсэн” [хасаг. *aqtaban shubirindi*] гэдэг бөгөөд хасаг үндэсний ухамсарт өнөөг хүртэл мэдрэгдсэн арилшгүй ул мөрөө үлдээсэн байна. Хэдийгээр хасагийн холбооныхон удалгүй Зүүнгарынхныг хөөн гаргаж байсан боловч, ойрад хасагийн хоорондох хүчирхийлэл Зүүнгарын улс 1758 онд бүрэн мөхтөл үргэлжилсэн юм.⁷ Энэ хүчирхийллийн нэг жишээ болгож Зүүнгарын Эринчиний харьяатууд хасагийн эсрэг үйлдсэн хэмээсэн нэг аллагын тухай айлтгалыг авч үзье: “Манай гуч илүү хүнийг алж эрчүүдийн бэлгийг цом огтолсон. Үүнд манай ард гайхаж барахгүй маш хорсмой. Энэ Зүүнгарын өөлд нарын зан маш муу⁸.” Дээр дурдсан Лобжиа нарын бүлэг бол Хасагаас зугтаж ирсэн ойрад нарыг тэмдэглэсэн анхны тохиолдол байсан юм. Үүнээс хойш Чингийн хязгаарт хасаг эздээсээ зугтсан ойрадууд бөөнөөр орж ирэх болов. Эхний энэ бүлэг хүмүүсээс ялгаатай нь тэд шашны ялгаанаас болж дүрвэгсэд бус байжээ⁹. Үзэн яддаг хасагуудын эрхэнд боол болж байхаар Чингийн эзэнт гүрний захиргаанд орохыг илүүд бодож байсан бөгөөд нэг хэсэг дүрвэгчид “бид хасагт халдан үхэх байтугай их эзэнд даган ороход хүрэхгүй хэмээн тогтоож” ирсэн хэмээн ярьжээ¹⁰. Энэ Зүүнгарын дүрвэгчдийн хүсэлт нь Чин улс ууланд нуугдаж буй махчин нарыг хядаж байсан цагтай давхцаж байгаа нь тун гайхалтай ч Зүүнгарын ойрадууд хасагийг үзэн ядах сэтгэл нь давамгайлж байсан учраас л тэдний эмс хүүхдийг хядаж байсан эзэнт гүрэнд дагаар

⁷ Чингийн засаг хасаг ойрадын хоорондох хүчирхийлэлд хэзээ анхлан анхаарлаа хандуулсан нь тодорхой бус. 1750-иад оны дундаас Чингийн засаг хасагийн дунд жузийн Аблайн тэргүүлсэн хасагууд Зүүнгарын нутгийг довтолж хүн олзлон аваачиж байгааг тодорхой мэдсэн бөгөөд жишээ болгож дараах зарлигийг авч үзье: “Эдүгээ Зүүнгарын бүх газрыг цөм шийтгэн тогтоов. Ганц Хасаг Зүүнгарын зүг эртнээс дайсан тул бас захыг орон дэмий уулгалан явж Зүүнгарын ард олж амгалан амьдарсангүй бөлгөө. Эдүгээ Зүүнгарын газар хүн цом манайх болов. Хасаг хэрэв бас урьдын адил дэмий уулгалан дээрэмчлэх болвоос яхан хэмээн болохгүй” [te jun gar i gubci ba be gemu ichiyame toktohuha. damu hasak. jun gar i baru daci dain ofi. kemuni jecen be dosime. balai tabcilame yabume. jun gar i urse bahafi elhe banjiraku bihe. te jun gar i ba na niyalma gemu musengge oho. hasak aika kemuni nenehe adali balai tabcilara durire oci. ainaha seme ojoraku.] Бандид буулгасан зарлигаас эшлэв. Банди, ТТ 20.07.16. MaLFZZ-ZHGD Vol I, Doc 3. Энэ довтолгоонуудын тухай би 2-р бүлэгт дэлгэрэнгүй өгүүлнэ.

⁸ [meni gūsin funcere niyalma be wafi haha niyalmai ergen jaka be gemu faitahabi. ede meni urse ferguweme wajiraku umesi korsohobi. ere jun gar ület sei banin umesi ehe.] Банди, ТТ20.07.25. MaLFZZ-ZHGD Vol I, Doc4.

⁹ Гэсэн хэдий ч тэдний дотор бас шашны зөррөнөөс болж дагаар ирсэн гэсэн ойрадууд байсан юм. Даваа хэмээгч ойрад хүн. “Номгүй хасагт амьдрах байтугай үхэвч оргон гарч их эзний албат болсугай хэмээн” [nomun aku hasak de banjire anggala. buccicibe ukame tucifi. amba ejen i albatu oki seme.] хэлж иржээ. Аргуй, ТТ 25.09.19. MaLFZZ 1844-011; 058-0296.

¹⁰ [muse hasak de adunggiyame buccere anggala. amba ejen de dahame dosire de isiraku seme toktobufi.] Юн Үй, ТТ 25.07.06. MaLFZZ 1832-011; 057-1035.

орохоор ирж байжээ¹¹. Энэ ойрад дүрвэгчдийн хувьд Чингийн төр ойрад хасагийн хооронд хэрэггүй мөргөлдөөн үүсэхээс сэргийлсэн бүхнийг хамарсан нэг зарчмыг барьж байв. Хасагууд удалгүй Чингийн төрд дагаж торго аван оронд нь адуу өргөж Чингийн цэрэгт тусалж эхэлжээ. Тийм учраас Чингийн тал хасагуудын дургүйцлийг хүргэж зүрхлэхгүй байв¹². Жишээ болгон, Хасагаас оргон ирэх ойрадуудыг хэрхэж байх тухай хааны зарлигийг авч үзье:

“Ойрад Харцагайг урьд хасагууд довтолж олзлон аваачсан бөлгөө. Хүнд ажил зүтгэн чадахгүй тул биднийг даган иржээ. Түүнийг хамгаалан авах нь зохистой боловч, эдүгээ хасаг нар бүгд соёлд дагажээ. Хэрэв урьд тэдний олзолсон хүн босч ирвээс, хойноос нь нэхүүлтэй бол эргүүлж өгвөл зохино. Хүн эс нэхэж ирэх болвоос олон үггүй хамгаалан автугай¹³.”

Хожим нь бусад ойрад нарт хамааруулан хэрэглэсэн¹⁴ энэ зарлиг, нэг талаас ойрад дүрвэгчдийг хамгаалалдаа авах гэвч нөгөө талаас хасагууд харилцаагаа муутгахгүй хичээсэн Чингийн бодлого яг сайхан харагдаж байна. Хасагууд нэхсэн тохиолдолд л ойрадын дүрвэгчдийг буцааж өгөх шийдвэр нь энэ эгзэгтэй байдалд таарсан шийдэл байв. Энэ ойрадуудыг бүгдийг нь цэргээр харгалзуулан өртөөгөөр Бээжинд хүргүүлсэн байжээ¹⁵. Хэрэв тэр замаар Бээжин хүртэл худалдааны хэргээр ямарваа хасагийн элчин төлөөлөгч явж байвал Чингийн албаныхан хасаг ойрадын хоорондох зөрчлийг сайн мэдэхийн

¹¹ Жишээ нь ТТ 25 оны 8 сард Агуй Хасагаас зугтаж ирсэн бөгөөд Бээжинд илгээсэн хэдэн ойрад хүний тухай айлтгал өргөжээ. Тэр айлтгалдаа тэр зуур Чингийн цэрэгт баригдсан Моохали, Пүрэв нэртэй хоёр махчингийн тухай “эд цом урьд удаа хядан алахад ойсон улс. Өршөөвөөс болохгүй тул, даруй цаазалжээ” хэмээн бичсэн нь нэг хэсэг ойрадыг хамгаалан авч байхдаа нөгөө нэг хэсгийг нь хядан алж байсан гэсэн үг юм. Агуй, ТТ 25.08.03. MaLFZZ 1839-005; 057-2536.

¹² Чин-Хасаг, Зүүнгар-Хасагийн харилцааны тухай энэ диссертацийн 2-р бүлэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

¹³ ТТ 24 оны 8 сарын 9-нд буулгасан энэ зарлигийг Юн Уй, ТТ 25.04.06. MaLFFZ 1817-008; 056-1739. айлтгалаас эшлэв. Эх хувийг нь олж чадаагүй болно. Энэ айлтгалд хасагаас оргож ирсэн таван ойрад хүнийг хойноос нь нэхээгүй тул Бээжинд хүргүүлсэн тухай бичжээ.

¹⁴ Юн Уй, ТТ 25.05.13 MaLFFZ 1822-028; 056-2881. Дожин, Тэса, Тас, Бая, Шар хэмээх таван ойрад хасагаас дагаар иржээ. Азтай оргож хасаг нар хойноос нь нэхэж ирээгүй тул тэднийг Бээжинд илгээжээ.

¹⁵ Эдгээр ойрадуудыг эхний үед Пижан, Аксу хоёрын аль ойрыг үзэн түр суулгаж тохиромжтой цагт нийслэл рүү илгээж байв. Шүхэдэ, ТТ 25.06.02. MaLFZZ 1828-029; 057-0341. Тэднээс маш бага хувийг нь Илд үлдээж элдэв ажилд зарж байсан аж. Жишээ нь, нэгэн бүлэг дагаар орсон 9 ойрадаас 8-ыг нь Бээжинд илгээтэл Аксуд түр суулгаж, үлдсэн Өлзий гэгчийг Илд үлдээж зарц болгожээ. Агуй, ТТ 25.07.20. MaLFZZ 1834-039; 057-1653. Заримуудыг нь тухайн орны албаны сайд нарт зарц болгон өгч байв. Даху хэмээгч ойрад, эхнэр Мэнд, түүний эхийн хамтаар Тэнгэр тэтгэсний 22-р оноос хойш олзлогдон зарцлагдаж байсан хасагийн гараас мултран гарч ирснийг түшмэдэд хуваан өгч зарц болгожээ. ТТ 25.01.20. MaLFZZ 1806-014; 055-2846. Бээжинд илгээж байсан ойрадуудыг ван, сайд нарт хуваан өгч зарц болгож байв. Фүхэн, ТТ 25.11.хх. MaLFZZ 1852-021; 058-1938.

хувьд элдэв хэрэг дэгдэхээс сэргийлэн ойрадуудыг тэдний араас их хол зайтай явуулж байв¹⁶.

Тэнгэрийн тэтгэсний 25 оны 9 сар хүртэл Хасагаас оргон ирэгч ойрадуудын ихэнхийг Бээжинд илгээж байв. Чингийн албаныхан тэднийг ямар нэг аюул учруулахгүй гэж үзэж эхлээд дүрвэгчдийн ихэнхийг Зүүнгарт эсвэл ойролцоо нутагт үлдэхийг зөвшөөрч, зөвхөн хуучин Зүүнгарын язгууртан тайж буюу зайсан нарыг Бээжинд илгээж байв. Энэ өөрчлөлт дараах зарлигт тусгалаа олжээ:

“Эдүгээ Зүүнгарын бүгд газрыг цөм мөхөөжээ. Хасаг Буруд нар цөм даган оров. Урьд оны хасагийн газарт оргон одсон өөлд нар хасаг нарын дарлахад тэсэхгүй удаа дараа оргон ирсэн нь бодвоос бас буй. Үүний дотор үнэн сэжиглэлтэй явдал бүхий, лав тайж зайсан урд байсан хүн болвоос нийслэл хотонд илгээвээс бас болмой. Хэрэв огт учиргүй хэрэглэхгүй хүнийг тусгайлан хүн гаргаж нийслэл хотонд илгээвээс огт шийтгэвээс нийлэх зүйлгүй бөлгөө. Өртөөний морийг зовоомой. Үүнийг Или, Үрүмчид суусан сайд нарт авч үүнээс хойш хасагаас оргон ирсэн өөлд нарын дотор хэрэв тайж зайсан урьд байсан хүн юуны ганц бие сэжиглэлтэй зүйл бүхийг нь хэвээр нийслэл хотонд илгээхээс гадна, хэрэв эм хүүхэд бүхий огт сэжиглэлтэй зүйл үгүйг нь нийслэл хотонд илгээхийг болиулж, даруй тэнд нийлэхийг үзүүлэн суулгатугай. Эднийг үлэмж суулган хүрээнд аж төрүүлсэн хойно эсхүл морь мал адуулуулан, эсхүл зэрх газар хэрэглэх болвоос бас хүчин олвоос болмой.”¹⁷

Энэ зарлигаас Чингийн төр энгийн ойрадуудыг аюул занал гэж үзэхээ больсныг харж болох боловч эзэнт гүрний захиргаа хуучин Зүүнгарын тайж, зайсан цолтонгууд мөн гэр бүлгүй буюу ямар ч алдах зүйлгүй эрсийг ямар нэг амар тайван бус явдал үүсгэж магадгүй гэж үзсээр байсан тул тэднийг Бээжинд

¹⁶ Юн Үй, ТТ 25.04.06, MaLFZZ 1817-008; 056-1739.

¹⁷ [te jun gar gubci babe gemu mukiye buhe, hasak, burut, se gemu dahame dosika, nenehe aniyai hasak i bade ukame genehe illet se, hasak sei adunggiyara de hamirakū, siran siran i ukame jiderengge, gūnici kemuni bi, erei dorgi yargiyan i kenehunjecuke ba bisire, ainci taiji jaisang de bihe niyalma oci, gemun hecen de benjibuci kemuni ombi, aika umai turgun akū oyomburakū niyalma be cohotoi niyalma tucibufi gemun hecen de benjibuci umai icihiyaci acara hacin akū bime, giyamun i morin be jobobumbi, erebe ili, urumci de tehe ambasa de gaifi, Ereci Julesi hasak ci ukame jihe illet sei dorgi, aika taiji jaisang de bihe niyalma, aici emteli beye kenehunjecuke hacin bisirengge be an i gemun hecen de benjibuci tulgiyen, aika hehe juse bisire umai kenehunjecuke hacin akūngge be gemun hecen de benjibure be nakafi, uthai tubade acara be tuwame tebukini, esebe labdu tebufi, kuren banjinaha manggi, aici morin ulha adulabure, aici takūsara bade baitalara oci, kemuni hūsun bahaci ombi.] Энэ зарлигийг Антайн айлтгалаас эшлэв. Антай, ТТ 25.09.10, MaLFZZ 1840-058; 057-3109.

илгээж байв. Хамгийн сонирхолтой нь уг зарлигийн төгсгөлд Тэнгэрийн тэтгэсэн хаан: *“Үрүмчийн газарт хасагийн ард басхүү худалдаалаар ирмой. Хасаг нар ирсэн хойно, ердөө эднийг уулан дотор зайлуулж тэдэнд мэдэгдэхгүй болвоос барав”*¹⁸ хэмээн тушаажээ. Зүүнгарт нэг ч ирж үзээгүй Тэнгэрийн тэтгэсэн хаан, хасаг нарыг худалдаагаар Үрүмчид ирэх тоолонд тэнд байгаа ойрадуудыг нуух гэдэг бүтэшгүй зүйл болохыг мэдсэнгүй байж магадгүй. Энэ зарлигийн хариуд Агуй харин эвтэйхнээр энэ асуудлыг шийдвэрлэх нилээд бодтой шийдлийг санал болгожээ. Тэдгээр ойрадуудыг Или юм уу Үрүмчид үлдээх нь хасагуудын дургүйцлийг төрүүлэх нь дамжиггүй тул хасагийн худалдаачдын огт явдаггүй Аксуд тэднийг илгээх юм бол Чингийн төр ойрадуудыг хүлээн авч байгааг хасагууд мэдэж чадахгүй. Хоёр гурван жилээс хасаг нарын мартсан хойно тэднийг харин Или эсхүл Үрүмчид суулгаж болох юм гэжээ. Тэнгэрийн тэтгэсэн хаан Агуйн айлтгалыг зөвшөөрч, сэжиг бүхий Бээжинд хүргэгдэх ойрад нараас бусад дүрвэгчдийг Аксуд түр суулгаж байх болов¹⁹. Ойрадуудыг Аксуд түр суулгах бодлого тийм удаан үргэлжилсэнгүй, Тэнгэрийн тэтгэсний 25-р оны 10 сард ойрад дүрвэгчдийг суурьшуулах, дараагийн арван жилд хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлжээ. Энэ шинэ зарлигаар бүх л ойрад дүрвэгчдийг нэг дор цуглуулж хуучин Зүүнгар улсын төв, Чингийн эзэнт гүрний засаг захиргаа бас төвлөх болсон Илим суулгах болжээ. Энэ аядуу бодлого нь хасагаас дүрвэн ирж байгаа ойрадууд Зүүнгар дахь Чингийн ноёрхолд аюул учруулахаа өнгөрсөн гэдгийг хаан болон Чингийн албаныхан ойлгож мэдсэнээс гарсан аж. Тэнгэрийн тэтгэсэн хаан өөрийн зарлигтаа эдгээр ойрадууд нь ямар нэг хэрэгт төвөг өдүүлээгүй тул тэдэнд энэрэнгүй хандах хэрэгтэй гээд Чингийн албаны түшмэдэд энэ аядуу шинэ бодлогыг ойрад дүрвэгчдэд: *“Та нар үнэн сэтгэлээр даган ирж элдэв хэрэг өдүүлсэнгүй. Хичээлтэй зүтгэвэл их эзэн та нарыг өршөөн хайрлана”* гэж ухуулахыг тушаажээ. Тэнгэрийн тэтгэсэн хаан түшмэддээ илүү нарийн заавар өгчээ:

“Манай түшмэд зөвхөн эднийг өөлд хэмээн бусчлан үзэж хүн болгохгүй. Эд хэдий өөлд боловч хүн болой. Тэдний дотор үнэн санаагаар зүтгэн явах нь байваас үнэн санаагаар өршөөн үзэх, муу ану байваас залхаан сургах болвоос зохьмой. Үүнийг Шүхэдэ,

¹⁸ [urumci i bade hasak i urse kemuni hūdašame jimbi. hasak sa jihe manggi. manggai esebe alin dolo jailabuficende sabuburakū oci. wajiha kai.] Дээрх айлтгал.

¹⁹ Агуй, ТТ 25.09.26. MaLFZZ 1845-027; 058-0568. Айлтгалын төгсгөлд Тэнгэрийн тэтгэсэн хаан Агуйн хүсэлтийг цохон зөвшөөрсөн бөгөөд энэ талаар тусгай зарлиг гаргасан гэсэн боловч би тэр зарлигийг нь олж үзэж чадсангүй. Дараа дараачийн айлтгалуудаас харин бид Агуйн хүсэлтийг зөвшөөрсөн болохыг мэдэж болно. Жишээ нь, Агуй, ТТ 25.09.26. MaLFZZ 1845-030; 058-0587. Шүхэдэ, ТТ 25.10.08 MaLFZZ 1848-034; 058-1109. Эдгээр айлтгалаас Агуйн хүсэсний дагуу Хасагаас оргож ирсэн ойрадуудыг Аксуд суулгаж байсныг мэдэж болно.

Агуй нарт захиж үүнээс хойш энэ мэт өөлд нарыг зарцлахад барьваас зохихыг дарангуйлан, өршөөвөөс зохихыг өршөөн сануултугай²⁰.”

Нэг жилээс бага хугацаанд ойрадууд хядаж арилгах ёстой хулгай нараас жинхэнэ хүн болж хувирав.

3. Хулгайгаас хүн болсон нь: *Махчинг* хядах бодлогын төгсгөл

Хасагаас оргон ирэх ойрад дүрвэгчдэд хандсан Чингийн аядуу зөөлөн бодлого аажмаар ууланд хоргодон нуугдаж буй *махчин* нарт шилжив. *Махчин* нарт хандах Чингийн бодлого 1761 онд өөрчлөгдсөн юм. 1761 оны эхээр гаргасан нэгэн зарлигтаа Тэнгэрийн тэтгэсэн хаан Зүүнгарт унасан их цас нь ууланд нуугдан хоргодож буй махчингууд хоол хүнс эрэн гарах тул урдын жишээгээр цэрэг илгээж тэдгээр хагас-өлсгөлөн махчингуудыг бариулахыг тушаажээ. Тэгэхдээ хаан Чингийн бодлогыг өөрчлөх цаг болсон гэж шийдээд:

“Эдүгээ махчинг шийтгэхэд урдтай харьцуулваас болохгүй. Яагаад хэмээвээс, энэ удаа хасагт эрэн одсон өөлд нар тэдний дарлахад тэсэхгүй удаа дараа нааш иржээ ... Эд нар бэрх уул завд зайлан нуугдан түр амь хэлтэрсүгэй хэмээн үүрлэсэн бахана. Тэдэнд бас ямар ялгаа бий аж. Эднийг шийтгэхэд одоо дуусан цагдан хядахыг эрэхгүй. Дагуулваас зохихыг дагуулан хурааваас сайн²¹.”

Чингийн цэрэг тэднийг “*бүгдийг нь арчин хаях*”-аар оролдсон ч чадахгүйгээ хүлээн зөвшөөрөөд, Тэнгэрийн тэтгэсэн хаан шинэ бодлого явуулж тэдгээр *махчингуудыг* бусад ойрад дүрвэгчдийн хамтаар Илим суулгах болов. Энэ шинэ чиглэлээ тайлбарлан:

“Энэ удаа *махчин нар хэрэв эрэн ирсэн нь байваас даруй хураан тэжээмөй. Эрэн ирэхгүй их цэрэгт баригдваас амь хэлтрүүлэхгүй алмөй, хэмээх зэрэг үгийг сэнхрүүлэн ухуулах*

²⁰ [musei ambasa urui esebe ület seme enculeme tuwame niyalma oburakū. ese udu ület bicibe. inu niyalma kai. ceni dolo unenggi gūnin faššame yaburengge bici. yargiyan gūnin i gosime tuwara. che ningge bici. isebume tacibure oci acambi. erebe šuhede. agūi sede jasifi. ereci julesi ere jergi ület sebe takūrsara de jafaci acarangge be jafatame. gosici acarangge be gosime huwekiyebukini.] Агуй, ТТ 25.11.20. MaLFZZ 1856-015; 058-2897.

²¹ [te i mahacin be icihiyara de nenehe de duibuleci oiorakū. adarame seci. ere sidende hasak de baime genehe ület se ceni adunggiyara de hamirakū siran siran i ebsi jiderengge...ese manggai alin holo de jafame somime taka erse guweki seme. tomoho dabala. cende geli ai encehe bini. esebe icihiyara de hono wacihiyame giyarime gisabure be baiburakū. dahabuci acaragge be dahabume bargiyaci sain.] Агуй, ТТ 26.02.04. MaLFZZ 1867-014; 059-1539.

бичиг зохиож газар газарт наан тэдэнд ухуултугай... бас эрэн ирэхгүй болвоос эрхгүй хядваас сая сайн²²."

Өөрөөр хэлбэл, Тэнгэрийн тэтгэсэн хаан хасагаас оргон ирж байсан ойрад дүрвэгчдэд хандан явуулж байсан тэр аядуу зөөлөн бодлогоо ууланд нуугдан буй махчингуудад хэрэглэхээр болгоомжтой шийдсэн гэсэн үг юм. Ямар ч гэсэн махчин ч бол, хасагаас оргож ирэгч ч бол хуучин нутагтаа эргэж ирвэл өршөөгдөх болжээ. Тэнгэрийн тэтгэсэн хаан ууланд хоргодон буй махчингууд нь Чингийн төрийг эсэргүүцэх хүчин болохоосоо илүүтэй харин хасагуудаас зайлан нуугдаж буйг мэдсэн бөгөөд чухам ийм учраас л Зүүнгарын хуучин дайсан байсан Чин улс тэднийг нөгөө нэг дайсан байсан хасагуудаас хамгаалах болсон юм.

Энэ шинэ аядуу бодлогыг хэрэгжүүлэхийн тулд Агуй том модон самбарууд дээр хааны зарлигийг тод үсгээр сийлүүлж Зүүнгар даяар *махчин* нарын хоргодон байж болох бүх газруудаар өлгүүлжээ. Тэр самбарууд дээр доорх үгсийг сийлсэн байв.

“Хааны зарлигаар, олон газар хоргодон суусан олон өөлд та нарыг үхэх ялаас хэлтрүүлэв. Таныг өршөөж хамгаалмой. Энэ зарлигийг даган орж ирэгсдийг үл алмой. Харин ч өршөөмой. Гагц дагаар ирэхгүй хоргодон сууваас манай их цэрэг хүрэн таныг барьж ялгалгүй хядан арилгамой.”

Энэ шинэ бодлогыг эхний үед нилээд болгоомжтой явуулж байсан бөгөөд, Агуй хэсэг эсэргүү *махчин* нар дагаар ирэхгүй, цаашид нуугдан тэнэх нь магад тул цэрэг илгээн ууланд хоргодон буй *махчин* нарыг хядаж арилгахыг айлтгажээ²³. Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигт, зөвхөн сайн дураараа бууж өгөхөөр ирсэн *махчин* нарыг өршөөж, харин ууланд Чингийн цэрэгт баригдвал шууд цаазлахаар заасан байжээ. Гэвч, хэрэг дээрээ Чингийн цэрэгт баригдсан *махчин* нарыг хэрэв зэвсэг барин эсэргүүцэл үзүүлээгүй бол өршөөж байсан нь магад бөгөөд *махчин* нарыг эрүүлэх харуул хайгуул томилж байсан нь урдын адил тэднийг хядахын тулд биш харин дагуулж авахын тулд илгээж байсан хэрэг юм. *Махчин* нарыг эрэх хайгуулын ангид голдуу солоон, цахар болон ойрад цэргүүд холилдон явдаг бөгөөд хайгуулд гарахаас нь өмнө тэдэнд,

²² [ere sidende mahacin sa aika baime jiderengge bici. uthai bargiyafi ujimbi. baime jiderakū. amba cooha de jafabuci erse guweburakū wambi. sere jergi gisun i neileme ulhibure bithe arafi. babade latubufi cende šambume ulhibukini...geli baime jiderakū oci. urunakū gisabuci teni sain.] эшилсэн айлтгал.

²³ [suweni jergi babade somiha jailaha ület urse be hesei wara be guwebufi bargiyafi ujibumbi. ede baime jihengge be gemu hese be dahame bargiyafi warakū ujimbi. aika balai jailame somime jiderakū oci. cooha isinaha nambuha be tuwame gemu gisabume wambi.] эшилсэн айлтгал.

“Хайгуулд гараад ямарваа махчин дугаа учирваас ойрад цэрэг авч тэдэнд хааны өршөөлийг ухуулан хэлүүлж бууж өгөхийг тушаагтун. Хэрэв тэд үл дагаваас даруй алж арилга” хэмээн зааварлаж байв.

Эдгээр хайгуулын ангиуд *махчин* нарын газар болон цасан дээр үлдээсэн мөрөөр тэднийг мөрдөх бөгөөд нэг удаа Чингийн хайгуул нэг хүний мөрийг мөрдөн явсаар модноос хэдэн морьд уяж тогоотой идээгээ тархаан хаясан хүнгүй буудал дээр явж очжээ. Хайгуулын анги мөрийг үргэлжлүүлэн мөрдсөөр гурван ойрад дүрвэгчийг олж харсан бөгөөд тэд Чингийн цэргийг хармагц тархан зугтсанд Чингийн *Хотон* нэртэй ойрад цэрэг тэдний араас ууланд орж *“Бүү ай! Би ч гэсэн хасагаас босч ирэн дагаар орсон ойрад хүн. Эдүгээ их эзэн хишиг хүртээж манай ойрадуудад нутаг өгч гурил будаа, мал хайрлав. Манай амьдралд элбэг хүрэлцэнэ. Та дагаар орхул бас мантай адил их эзнийг өршөөлийг хүртмой”* гэж хашгирч явжээ. Тэдгээр гурван ойрад байлдалгүй бууж өгсөнд даруй Илим суулгав. *Махчин* нар бүгд Чингийн өршөөлийн самбарыг олж үзээгүй нь мэдээж. Тийм ч учраас тэд Чингийн цэргээс айн нуугдсаар байв. Жишээ нь, Тэнгэрийн тэтгэсний 27-р оны 3 сард Чингийн хайгуул ангитай таарсан арван дөрвөн *махчин* цэргийн барааг хармагц тарж зугтсан Чингийн ойрад цэргийг илгээж байлдалгүй бууж өгөхийг хэлүүлжээ. Тэднийг бариад байцаахад, хоёр жил гаран Чингийн цэргээс нуугдан ууланд хоргодож ан хийж амь тэжээж байснаа өчсөнд Чингийн цэргийн дарга тэднийг *“Богд эзний өршөөлт санаанд нийлүүлэн цом хураан тэжээмой. Хэрхэвч хэмээн алахгүй, хэмээх зэрэг үг бичсэн мод тэмдгийг замын гудас, их замын байдалтай газарт цом өлгөсөн билээ”* хэмээн тайвшруулжээ. Чингийн цэргийг хармагц зугтан байсан *махчин* нарын энэ байдал нь Чингийн тэдгээр зарласан тэмдэгүүд тэдэнд хүрч чадаагүй болохыг харуулна. *Махчин* нарыг үзэгдсэн газар нь хядан устгаж байсан Чингийн түрүүчийн бодлогыг санах юм бол тэдгээр дүрвэгчдийн болгоомжлол тун ойлгомжтой болох юм²⁴. Гэхдээ ууланд нуугдан буй ойрад дүрвэгчдээс зарим нь Чингийн төрөөс өлгөсөн модон самбаруудыг олж үзсэн шиг байна. Тэнгэрийн тэтгэсний 27-р оны 12 сард, *Бүргүн* хэмээгч эр, эм *Үлэмж*, *Үлэмжийн* эгч *Есэн* болон нэг залуу охины хамтаар харуулын цэрэгт дагажээ. Долоон жилийн урд Зүүнгарын дотоод самуунаас зайлахын тулд Бор талд очиж суугаад хасагуудад баригдан *Мирзагелд* хэмээгчид зарцлагдаж байгаад хоёр жилийн урд тэндээсээ оргон гарчээ. Тэгээд ууланд гарч ан хийн амь зууж өөр хүмүүстэй таарсангүй, Чингийн цэрэг Зүүнгарыг эзэлснийг ч мэдээгүй зүгээр ууланд ойрад босгуул нарыг өршөөсөн тухай модон самбар үзээд бууж

²⁴ [enduringge ejen i gosingga gūnin acabume gemu bargiyafi ujimbi. ainaha seme warakū. sere jergi gisun araha moo i šusihe be jugūn i unduri amba jugūn arbungga bade gemu lakiyaha.] Жингэри, ТТ 27.03.08. MaLFZZ 1929-006; 062-1267.

ирсэн хэмээжээ.²⁵ Тэд нар өөрсдөд нь хор хүргэж болох, юуны өмнө хасаг нараас зайлахаар хичээсэн ч энэ боломжгүй зүйл байсан юм. *Махчин* нарын дийлэнх нь Чингийн цэргээс айж байсан боловч, бусад нь хасагт олзлогдон боол болохоос л эмээж байв. *Ургул* хэмээгч нэг ойрад ийм хүнд хэцүү нөхцөлд сууж байснаа “*Манай энэ зэрэг махчин Хасаг, Буруд нарын уулсалан барихад айж цөм буйд уул, их ойн зэрэг хүн хүрэхгүй мөр гарахгүй газрыг эрэн явмой*” хэмээн тайлбарлажээ²⁶. Олон *махчин* бараг арваад жил өөр хүмүүстэй харилцалгүй бүгэн суужээ. *Төгсбаатар* хэмээх ойрад *махчин* эхнэр, охины хамтаар найман жил Ахур Харахайн ууланд ан хийн амь зуужээ. Чингийн харуулд орж ирэн дагаар орж түүнийг байцаасан түшмэдэд, “*Энэ хэдэн жил би хасагаас айж огт хүн хүрэхгүй их хад бургас шугуйн дотор яван гөрөөчлөн амьдарсан билээ. Илйд нутаг болсон явдлыг ор мэдэхгүй. Мөн бус махчин учирсан явдал үгүй*” гэжээ²⁷. Миншүй саяхан дагаар орсон өөр нэг бүлэг *махчингийн* олон жилээр ертөнцөөс тусгаарлагдсан байдлыг нь, “*Эр эм их бага бүгд гөрөөсний арьсан дээл өмсчээ. Арван хэдтэй хүүхэд тэмээ үхрийг цөм танихгүй, гүн уул ойд байсан нь үнэн*” хэмээн цохон тэмдэглэжээ²⁸.

4. Ойрадуудыг Илйд нутаглуулсан нь

Хасагаас дагаар орсон хийгээд бууж өгсөн *махчин* нарыг Илийн хөндийд суулгаж байв. Хожим эдгээр ойрадуудыг хойшоо Тарвагатайд бас нутаглуулжээ²⁹. Чингийн харуул дээр ирэхэд нь тэднийг байцааж дараа нь цэргээр харгалзуулан Или эсвэл Тарвагатайд хүргүүлэн тэнд нутаглуулж

²⁵ Асхан, ТТ 27.12.17, MaLFZZ 1998-012: 065-3164.

²⁶ [meni ere jergi mahacin. hasak. burut sei tabcilara jafara de geleme. gemu somishün alin. amba weji i jergi niyalma isinarakū. songko tucirakū babe baime yabumbi.] Mingsui, QL28.10.22. MaLFZZ 2058-020. 069-0417.

²⁷ [ere udu aniya bi hasak de geleme. damu niyalma isinarakū. amba hada bujan šuwa i dolo yabume guguşeme banjimbihe. ili de nukte oho babe oron sarkū. inu gūwa mahacin teisulehe ba akū.] Миншүй Төгсбаатар нарыг дагуулж аваад ууланд нуугдан буй махчин нарыг хэрхэх тухай нэгэн айлтгал бичиж өргөжээ. “Энэ зэрэг үлдсэн махчин бодвоос үлэмж үгүй боловч, гүн уул шугуйн далд бас хоргодон суусан нэг хоёр хүн бүхийг мөн үгүй болгон чадахгүй. Эд хүн хүрэхгүй газарт зайлан нэгмөсөн гарахгүй...тусгайлан хүн зарж нэгжин байцаавч бүхий буйд газрыг мөн хүрч чадахгүй. Явдалд хүн мал зовмой. Ийм учир эдүгээ цэргийн гэрийн мод цавчих элдэв алба зарлагад явах жич гөрөөчлөх ардал боолчууд цөм тушааж аливаа нэгжвээс зохих газрыг санаа сүвэгчлэн байцаан нэгжүүлэн” [ere jergi funcehe mahacin gūnici labdu akū bicibe. šumin alin bujan šuwa de kemuni somime tehe emu juwe niyalma bisire be. inu akū obume muterakū. ese niyalma isinarakū bade jailafi. fuhali tucirakū...cohome niyalma takūrafī suweleme baicacibe. bisirele somishün babe inu akūname muterakū. bai niyalma ulha jobombi. uttu ofi. ne coohai boo i moo sacire eiten alban takūran de yabure jai gurguşere urse de ahasi gemu afabufi yaya suweleci acarā ba be gūnin werešeme baicame suwelebumē.] Миншүй, ТТ 28.06.25. MaLFZZ 2039-020: 067-3060.

²⁸ [haha hehe amba ajige gemu gurgu sukū teile etuhebi. juwan udu sei juse. temen ihan be gemu takarakū. šuwe alin weji de bihengge yargiyan.] Миншүй, ТТ 29.08.17. MaLFZZ 2103-039: 071-2697.

²⁹ Би энд зөвхөн товч дурдаад өнгөрсөн боловч, энэ диссертацийн гуравдугаар бүлэгт тодорхой өгүүлнэ.

байв³⁰. Ойрадуудыг *ниру* хэмээх суманд хуваан оруулна³¹. *Ниру* хэмээх сумдын тоо хасагаас дагаар ирж Илид суулгасан ойрадуудаар өсч байв³². 1767 онд Ойрад сумдыг найман хошуу болгон өөрчилжээ³³. Ойрад дүрвэгчдийн ихэнх нь аймшигтай ядуурсан, ямар ч малгүй байх нь олонтоо байв. Агуй нар тэдний хөөрхийлөлтэй байдлыг айлтгасны сүүлээр Тэнгэрийн тэтгэсэн хаан зарлиг гаргаж тэдгээр дүрвэгчдэд хувцас болон мөнгө олгох болов³⁴. Энэ зарлигийн дагуу дөнгөж амь залгуулж буй ойрадуудад нэг лан мөнгө хоёр боодол даавуун хувцас өгөх³⁵ бөгөөд энэхүү “хишиг хүртээлт” хир чинээг нь харгалзахгүй бүх ойрадуудыг хамарч байв. Илид нутаглуулсан бүх ойрадуудад нэг лан мөнгө авах бөгөөд ядуучууд нь хоёр боодол даавуун хувцас авах болжээ³⁶. Илид суулгасан шинээр дагаж орсон 1200 ойрадад энэ зарлигийн дагуу эд зүйл өгөх болсон бөгөөд Миншүй нар энэ зарлиг гарснаас хойш олонх нь ихэд ядуурсан 1000 хүн нэмж Илид ирснийг айлтгав³⁷. Хожим энэхүү “хишиг хүртээлт” нэгэн хэвд орж, шинэ дагаар ирсэн ядуу ойрад нарт мөнгө хувцасыг бүрэн олгож, өөрийн мал ахуйг авч ирэгсдэд хагасыг нь олгох болжээ³⁸. Шинэ дагасан ойрадуудад бас тарих үр тариа өгч байв³⁹.

Чингийн засгаас мөн гэр бүлээсээ хагацаж салсан хүмүүсийг эргүүлэн нийлүүлэх ажлыг их хийжээ. Дайны үймээн самууны үеэр олон айл хагацаж сарнисан нь мэдээж. Хасагууд тэднийг довтлон олзолж аваачихдаа ихэвчлэн гэр бүлээс нь салгадаг байв. Эднийг дагаар ирмэгц төрөл саданг эрүүлсэн бичиг Үрүмчи, Или, Тарвагатайд илгээж, ямар нэг төрөл нь эдгээрийн аль нэгэнд байгааг мэдвэл тэднийг гэр бүлтэй нь нийлүүлж байв. Тэнгэрийн тэтгэсэний 26-28-р оны хоорондох, гэр бүлтэй нь нийлүүлсэн ойрадын дүрвэгчдийг жишээ болгон хүснэгтээр харуулья.

³⁰ Хасагаас дагаар ирсэн ойрадуудыг хэрхэж байх тухай энд тодорхой бий: Агуй, ТТ 31.04.01. MaLFZZ 2185-003; 077-0043.

³¹ Агуй, ТТ 25.11.20. MaLFZZ 1856-015; 058-2897.

³² Агуй, ТТ 32.06.27. MaLFZZ, 1939-026, 062-3131. Энэ айлтгалыг бичиж байх хооронд ойрад сумдын тоо хоёроос зургаа болж өссөн байв.

³³ Агуй, ТТ 32.06.27. MaLFZZ 2232-044; 080-0504. Энэ айлтгалыг бичиж байхад Илид аль хэдийн 14 ойрад сумтай болсон байв. Ойрадуудыг оруулсан найман хошууны нэгж нь бидний мэдэх Манж, Монгол найман хошууны бүтэцээс өөр байсан бололтой. Ойрадын найман хошуу нь Цахарын найман хошуутай илүү төстэй байсан шиг бөгөөд би үүний тухай диссертацийн гуравдугаар бүлэгт авч үзнэ.

³⁴ Агуй, ТТ 27.03.24. MaLFZZ 1935-010; 062-2302.

³⁵ Миншүй, ТТ 28.11.20. MaLFZZ 2063-042.1; 069-1803. —ээс эшлэв. Уг зарлигийн эхийг олж тулгаж чадсангүй.

³⁶ Агуй, ТТ 27.илүү05.15. MaLFZZ 1949-007; 063-1669.

³⁷ Миншүй, ТТ 28.11.20. MaLFZZ 2063-042.1; 069-1803.

³⁸ Миншүй, ТТ 29.06.29. MaLFZZ 2096-013; 071-1161.

³⁹ Миншүй, ТТ 28.03.04. MaLFZZ 2015-016; 066-2360.

Хүснэгт 1: Ойрад нарыг гэр бүлтэй нь нийлүүлсэн нь

Нэр	Гэр бүлтэй нь нийлүүлсэн он	Төрөл садных нь нэр/ ургийн сүлбээ	Эргэж нийлсэн газар	Эшлэл	Тайлбар
Учарал	ТТ 26	Даваа/авга; Бямба/эгч	Үрүмчи	MaLFZZ 059-0329 ТТ 26-01-03	Даваа, Бямба хоёр Гансугаас Илд, Аксу, Үрүмчид хүргэж явсан 170 ойрадын дунд байжээ. Үрүмчийг өнгөрч явахдаа тэд тэнд сууж байсан Учралтай таарж бүгд нийлэн тэндээ суухаар болов.
Энх	ТТ 26	Содцун / эрэгтэй дүү		MaLFZZ 059-0840 ТТ 26-01-11	Дайны үеэр бие биесээ хагацсан [nenem dain i usuri fakeaf]. Содцун Ирид гүн Мооса, Хаким бекийн зарц болж, Энх нь тэнүүлэн явсаар Гансугийн Сужоуд хүрч байгаад тэндээсээ гарч явах замд дүүгээ олж уулзжээ.
Хошочи	ТТ 26	Носхай / хүү		Дээр эшилсэн айлтгал	Носхай дайны үед эцгээсээ салж Ирид гүн Мооса, Хаким бекийн зарц болсон байжээ.
Манжи	ТТ 26	Отхон / эхнэр		Дээр эшилсэн айлтгал	Дайны үед эртэйгээ суусан бөгөөд нөхөр нь "Фү жанжин"-ы цэрэгт алба хааж яваад Сужоуд очиж суугаад байжээ. Энэ хооронд эхнэр нь Ирид гүн Мооса, Хаким бекийн зарц болсон байсныг эргэн нийлүүлжээ.
Бохолдай	ТТ 26	Басан болон Орос / бөлүүд		Дээр эшилсэн айлтгал	Дайны үеэр Бохолдайн нутагт цочирч өвчин дэлгэрч дүрвэхдээ төрөл саднаасаа хагацжээ. Басан, Орос хэмээх хоёр бөл нь Музартын даваагаар давж цахар цэргийн зарц болоод байв.
Мөнх	ТТ 26	Самтан / бөл		MaLFZZ 059-1533 ТТ 26-02-04	Хасаг Исбасар өөрийн ойрад боол Мөнхийг өргөсөнд түүний бөл Самтантай нийлүүлжээ.
Мөнх	ТТ 26	Шооргажи / авга	Алтай	MaLFZZ 060-0034 ТТ 26-05-24	Хасагууд авгынхаа нутаг Алтай руу өргөсөн Мөнхийг нэхсэн боловч Чингийн тал түүнийг буцааж өгсөнгүй авгад нь нийлүүлжээ.
Жаргал	ТТ 26	Төмөр / ах	Или	MaLFZZ 060-2879 ТТ 26-08-20	Жаргал хасагаас оргож ирээд Илд суусан ах Төмөртэйгээ нийлэхийг хүсчээ.

Өлзий	ТТ 27	Дашданзан / эрэгтэй дүү	Үрүмчи	MaLFZZ 065-0800 ТТ 27-10-27	Өлзий Илиэс Үрүмчид очиж дүү Дашданзантайгаа нийлэхийг хүссэнд зовшоорч Үрүмчийн сүмд суулган ном уншуулжээ.
Гэсэрхэ	ТТ 28	Хотон / хүү	Или	MaLFZZ 066-3446 ТТ 28-03-28	
Балу	ТТ 28	Манни / үеэл	Или	Дээр эшилсэн айлтгал	
Басан	ТТ 28	Болон / ах; Сандуба / эгч; Жаргал / эх	Или	MaLFZZ 067-1988 ТТ 28-06-05	Басангийн ах, эгч, эх гурав Үрүмчид сууж байсныг Илим илгээж нийлүүлэн суулгажээ.
Зодбааж ун	ТТ 28	Хотола / эрэгтэй дүү; эх	Захчин нутаг	Дээрх	

Ойрадын дүрвэгчдийн талаар Чингийн төрөөс явуулсан бодлого үндсэн хоёр зарчим барьж байсныг бид харлаа. Нэгд, Чингийн засгаас Зүүнгар дахь аюулгүй байдлаа нэн тэргүүнд тавьж байв. Ойрадын дүрвэгчдийн хөлс хүчийг ашиглахаар хичээж байсан боловч хуучин Зүүнгарын улсын язгууртнуудыг Чингийн засаглалыг эсэргүүцэх хүчин болохоос болгоомжилж, тэднийг элдэв хэрэг дэгдээхээс сэргийлэн Бээжинд илгээж байхыг тушаасан аж. Зүүнгарын эдгээр дүрвэгчдийн ихэнх нь Чингийн засагт ямар нэг аюул занал учруулахгүй нь гэдгийг гадарлаж эхлээд тэднийг Илим суулгах болов. Хасагаас оргон ирэх ойрадын дүрвэгчдэд хандан явуулсан энэ аядуу бодлого нь эцэстээ ууланд нуугдан хоргодож байсан *махчин* нарт шилжин хэрэглэгджээ. Чингийн бодлогыг тодорхойлсон хоёрдахь зарчим бол Хасагуудтай эвдрэлцэхгүйг хичээх явдал байж. Чингийнхэн Хасагаас оргосон ойрад боолуудыг өмгөөлөлдөө авснаар Чин-Хасагийн харилцааг нөлөөлж болохыг ойлгож байв. Эхэн үедээ хасагуудыг энэ талаар мэдэхээс сэргийлж байсан бол дүрвэгчдийн тоог нэмэгдэхийн хирээр цаашид тэднээс нууж байх бололцоогүй болжээ. Тэгээд үнэн хэрэг дээрээ босгуул ойрадуудыг тойрсон асуудал Чин-Хасагийн харилцааны ярвигтай асуудлуудын нэг болж хувирсан юм. Бид одоо Чингийн

төрөөс ойрадуудад хандаж явуулсан бодлого нь тэдний Хасагтай харилцах харьцаанд ямар уршиг дагуулсныг шинжилж үзье.

5.Эзэн бүх албатаа хайрлана: Чин-Хасаг-Ойрадын харилцаа

Зүүнгар дахь ноёрхлынхоо эхний жилүүдэд Чингийн засаг Хасагтай харилцаагаа муутгахгүйгээр ойрадуудыг өмгөөлөлдөө авах бодлого баримтлахыг хичээснийг бид үзлээ. Хожим, 1762 оноос эхлээд ойрадын босгуул нарын талаар Хасагтай харилцах харьцаагаа нилээд задгай болгожээ. Чин Хасагийн хооронд харилцсан олон тооны манж хэлээрх баримтууд Чингийн тал ерөнхийдөө ойрад боолуудаа буцаан нэхсэн хасгуудын шаардлагыг няцааж байсныг харуулна. Оргодлуудыг буцааж өгөхгүй гэх Чингийн талын гол үндэслэл нь тэд эзний албат болсон гэдэгт оршиж байв. Дотоод Азид *albatu* хэмээх нь харьяат, зарцыг хэлдэг бөгөөд албат нь эзэндээ алба хаах үүрэгтэй байдаг. Японы судлаач Онума Такахиро саявтархан Чин болон Хасагийн дундад жузийн хоорондох харилцааг голлон шинжилж, Дотоод Азийн улсуудын хоорондох харилцааг ойлгоход эзэн-албатын харилцаа нь шинэ чиглэл болох юм гэж үзжээ⁴⁰. Зүүнгарын дүрвэгчдэд хандсан Чингийн бодлогыг ойлгоход бас эзэн-албатын харьцааны онол нь тун чухал юм гэж би үзэж байна. Чингийн засгийн бодлогоор нэг албатыг нөгөөгөөс дээр үзэхгүй, харин ч эзний бүх албатыг эрх тэгш хандах ёстой байв. Чингийн төрийн үзэхээр Зүүнгарын улс мөхсөнөөр бүх л ойрадууд эзний албат болсон аж. Энэ логикийн дагуу, ойрад нарт хасагуудыг оролцуулаад эзний бүх л албат нарын адил хандах ёстой. Энэ зарчмыг 1762 оны нэгэн айлтгалд “Өөлд ч болог, хасаг ч болог бүгд эзний албат. Хэн алиныг нь өмөөрвөөс болохгүй. Гагцхүү шударгаар авмой”⁴¹ гэсэн байдаг. Зүүнгар дахь Чингийн засаглалын эхний арван жилд энэ зарчим ер хөдөлсөнгүй. Бараг долоон жилийн дараа 1769 онд, хааны зарлигт нөгөө л зарчмыг “Өөлд нар их эзний албат хэмээвээс хасаг мөн их эзний албат. Газар хэдий өөр байвч цом нэг адил албат болой. Огт ялгах зүйл үгүй”⁴² гэсэн байдаг. Хасагийн оросон ойрад боолуудаа буцаан авах хүсэлтийг Чингийн тал, нэг албатыг нөгөөгөөс илүүд үзэхгүй гэдэг зарчмаар байн байн татгалзаж байв. Жишээ нь, 1763 онд, хасагийн хэдэн ноёд Тарвагатайн ойролцоох Айтансу хэмээх газар Чингийн

⁴⁰ Onuma Takahiro. “Political Relations Between the Qing Dynasty and Kazakh Nomads in the Mid-18th Century: Promotion of the ejen-albatu Relationship,” in A Collection of Documents from the Kazakh Sultans to the Qing Dynasty. TIAS Central Eurasian Research Series, Special Issue 1, 2010. see doc 54 vol I

⁴¹ [ület ocibe. hasak ocibe. yooni amba ejen i albatu. yaya we be haršaci ojorakū. damu tondoï gamambi.]

Agūi, QL27.08.03. MaLFZZ 1963-014; 064-1083.

⁴² [ület se amba ejen i albatu seci. hasak inu amba ejen i albatu. ba udu encu bicibe. gemu emu adali albatu kai.umai ilgabure hacin akū.] Юнгүй, ТТ 34.07.26. MaLFZZ 2326-004; 086-1049.

түшмэдтэй чуулган нийлж ойрадын босгуулуудыг буцааж өгөхийг шаардсанд Чингийн тал эдгээр ойрадуудыг буцааж өгөхгүй хэмээн дахин давтан хэлжээ. Чингийн түшмэл Айлунга, хасаг нар энэ асуудлыг бараг хоёр жилийн дараагаар бас дахин сөхөж хасаг хэлээр бичсэн захидал Зүүнгар дахь Чингийн түшмэдэд авч ирсэнд ихэд эгдүүцэж энэ захидлын тухай хаанд өргөсөн айлтгалдаа:

“Уржнан жил Айтансугийн газарт, Абулбис олон тайж, ахалсан хүнийг авч, жанжин хэбэй амбан надад золгон ирсэн учирт даруй өөлд босгуулын хэргийг лавлан асуусан бөлгөө. Тэр цагт бидний бие Абулбис нарт тушаасан газарт, урьд Зүүнгар аймаг их ял өдүүлсэн учирт богд эзэн цэргийн хүчээр төвшитгөн тогтоож хотол өөлд, бүгд даган орж албат болсон. Үүнд, ойн гарч хасагт бүхий өөлд нарыг бидний санаанд мөн зүй нь авбаас зохимуй. Гагцхүү богд эзэн танай хасагийг нэг адил албат хэмээн өршөөн, ойсон өөлдийг удаан тэжээв. Байваас байтугай. Хэрэв авбаас хасагийн мунхаг санаанд сая албат болж байтал, даруй хүн байтугай авмой хэмээн дэмий айхыг болзвоос болохгүй хэмээн тийнхүү авсан явдал үгүй. Энэ даруй их эзний хишиг. Үүний дотор бие дураар Илип орж ирэх өөлд байваас уг газарт одсон болой. Яахин танай босгуул хэмээвээс болмой хэмээн ухуулан сургаж тушаасан хойно, Абулбис нар санаа даган маш зөвшөөсөн бөлгөө. Эдүгээ энэ нэгэн зүйлийг бас бичигт оруулан бичсэн ямар санаа буй. Маш буруу болжээ.”⁴³

Айлунга гол нь Чингийн засаг хасаг болон ойрад хоёул албат учир тэдэнд адилхан хандах учиртай гэсэн санал гаргажээ. Өөр нэг жишээ гэвэл, Хасагийн дундаж жузийн Аблай, Чинд дагасан Жанкиши хэмээгч ойрадыг нэхсэн явдал юм. Тэнгэрийн тэтгэсэн энэ талаар гаргасан зарлигтаа, эзэн албатын харилцаагаар Хасагийн ойрад боолуудыг буцааж өгөхгүй шалтгааныг тайлбарлажээ.

⁴³ [cara aniya aitangsu i bade. abulbis geren taiji ahūcilaha niyalma be gaifi. jiyanggiyūn hebei amban mende acanjiha nergin de. uthai ūlet ukanju i baita be dacilambi fonjiha bihe. tere erinde meni beye abulbis sede afabuha bade. onggolo jun gar aiman amba weile necihe turgunde. enduringge ejen coohai hūsun i necihiyeme toktobufi. gubci ūlet. yooni dahame dosifi. albatu oho. ede fifafi. hasak de bisire ūlet sebe. meni gūninde inu giyan i gaici acambi. damu enduringge ejen suweni hasak be emu adali albatu seme gosime. fifaka ūlet be goidame ujia. bici bikini. aika gaici. hasak i hūlhi de aimaka teni albatu ofi. uthai niyalma anggala gaimbi. seme balai gelere be boljoci ojurakū seme tuttu gaiha ba akū. ere uthai amba ejen i kesi. erei dorgi beye cisui ili de dosinjire ūlet bici. da bade mariha kai. adarama suweni ukanju seci ombini seme ulhibume tacibume afabuha manggi. abulbis se gūnin dahame umesi uruŋche bihe. te ere emu hacin be. geli bihe de dosimbume arahangge ai gūnin biheni. umesi waka oho.] Айлунга, ТТ 30.04.18. MaLFZZ 2140-002; 074-0024

“Үүнийг Миншүйд захигтун. Энэ удаад Абулай хэрэв хүн зарж юм зүйл авах Жанкишийг дурдах болвоос, даруй өөлд хасаг цөм их эзэн даган өршөөж нэг адил албат болсон. Жанкиши эрэн ирвээс хураамой хэмээх байтугай хэн алин ч ирвээс цөм хураах болой. Та бас их эзний хүнийг та бас дэмий авбаас болно уу. Танай бичигт бас хасаг сайн уу, өөлд сайн уу гэх үг буй. Танай хасаг уулаас цөм өөлд нарт алба барьж албат болон ирсэн бөлгөө. Их эзэнд даган орсоноос таныг маш хол газрын гадаад аймгийн хүн хэмээн өөлдөөс бас давтал хишиг хүртээсэн явдал бий. Өөлд нар сайн болвоос тэжээмой. Муу болвоос даруй сөнөөмой. Таныг мунхаг хасаг хэмээн даруй баахан буруу явбаас мөн уучлан хэлтрүүлэх бөлгөө. Та энэ учирт даруй дэмий хөөрөн яахин хэмээж болохгүй...өөлд хасаг цөм их эзний боол. Жанкиши нэгэнтээ эрэн ирж их эзэн хишиг хүртээн хиа тавьсан болой. Та дэмий эргэлзэн авсугай хэмээсэн нь машид буруу болжухуй хэмээсэн”⁴⁴.

Заримдаа Чингийн талаас Хасагаас босч ирсэн ойрадуудыг буцааж өгсөн тохиолдол байжээ. Чингийн талаас ойрадын босгуулуудыг эргүүлэн өгөхдөө мөн л тэр эзэн-албатын журмыг баримталжээ. Жишээ нь, Бэбэк хэмээх ойрад охиныг наян настай Долотбай хэмээгч хасагт богтлогдсон авч оргон гарч Чинд дагажээ. Долотбайн хүү араас нь нэхэн ирж эцэг нь ойрад эхнэртээ их хайртай алга болсноос нь хойш их үгүйлж байгаа тул буцааж өгөхийг Чингийн түшмэдээс гуйжээ. Бэбэк нь харин арван нэгэн жилийн урд хасагт баригдахаасаа өмнө Пүрэв хэмээгч ойрад хүний эм болж явсан гэж мэдүүлсэн бөгөөд тэрхүү Пүрэв Илим сууж байсныг байцаахад эмтэйгээ буцаж нийлүүлэхийг гуйжээ. Энэ хэргээс үүдэн хоёулаа л эзний албат гэгдсэн хасаг, ойрад хоёрын мэдүүлгийн хооронд сонгох төвөгтэй байдал үүссэн байна. Чингийн түшмэл Барпин дараах маягаар шийджээ:

⁴⁴ [erebe mingšui de jasifi. ere sidende abulai aika niyalma takūrafī jaka hacin gaire jangkiši be jonoro oci. uthai ūlet hasak gemu amba ejen dahame gosifi emu adali albatu oho. jangkiši baime jici bargiyambi sere anggala. yaya we jici gemu bargiyambikai. suwe geli amba ejen i niyalma be suwe geli balai gaici ombio. suweni bithede geli hasak saiyūn ūlet saiyūn sere gisun bi. suweni hasak daci gemu ūlet sede alban jafame. albatu ome jihei bihe. amba ejen de dahame dosika ci. suwembe umesi goro ba i tulergi aiman i niyalma seme ūlet ci hono dabatala kesi isibuha babi. ūlet se sain oci ujimbi. ehe oci uthai gisabumbi. suwembe hūlhi hasak seme uthai majige waka yabuci inu oncodome guwebumbihe. suwe ere turgunde uthai balai takdaci ainaha seme ojurakū...ūlet hasak gemu amba ejen i aha. jangkiši emgeri baime jifi. amba ejen kesi isibume hiya sindaha kai. suwe balai erehunjeme gaiki sehengege ambula waka ohobi seme.] Аргүйд буулгасан зарлиг. ТТ 27.9.13. Manchu Court Letter Record, Document number: 03-129-4-064.

“Бэбэк, Пүрэв хэдий харилцан эр, эм хэмээн таньсан авч, үнэн худлыг нэгмөсөн байцаах тэмдэг үгүй болгоо. Их улсын албат болохоос урдах хэрэг. Эдүгээ хотол хасаг нар болвоос, богд эзний өршөөл хуульд дагаж, арван хэдэн жил болов. Долотбай, Бэбэкийг бага эм болгосон нь бидэнд албат болсоноос хойших хэрэг...хэрэв Зүүнгарын улиралын хооронд тэмдэг үгүй эр эм болгоо хэмээх нэг үгийг зүтгэн түүний арван нэгэн жил эр эм болсон хүнийг хойш олгохгүй болвоос богд эзний дотоод гадаад боолчуудыг нэг адил илбэн өршөөх туйлын санаанд нийлэхгүй хэмээн санана⁴⁵.”

Өөрөөр хэлбэл Барпин Долотбайн оргосон эхнэрийг буцааж өгөх болсон шалтгаан нь, тэр босгуул эм Долотбайг албат болсны хойно түүний эхнэр болсон бөгөөд харин Пүрэвтэй түүнийг Чингийн албат болохоос өмнө сууж байсан гэдэгт оршиж байжээ. Бас өөр нэгэн тохиолдолд, оргосон эхнэрээ нэхэмжилсэн Олчун хэмээх хасагийн хүсэлтийг эс зөвшөөрсөн нь, тэр Дарган хэмээх ойрад эмийг Чингийн албат болохоос өмнө авсанд болсон аж⁴⁶. Бас Атахай хэмээх хасаг Чингийн түшмэдээс өөрийн босгуул 14 ойрадыг нэхэмжилсэнд “Ойрад, хасаг бүгд их эзний албат. Эрэн орсон ойрадыг цөм хураана” хэмээгээд буцааж өгсөнгүй ч тэдний дундаас Атахайн эм гэгдсэн нэг эхнэрийг харин буцаан өгчээ⁴⁷.

Зүүнгар дахь Чингийн ноёрхолын эхний арван жилүүдэд ойрад босгуулуудын асуудал Чин-Хасагийн харилцаан дахь шүдний өвчин болсоор иржээ. Энэ өгүүлэлд би зөвхөн 1759-1771 оны хоорондох үйл явдлыг авч үзсэн болно. Хэдий тийм байлаа ч хэзээ ч Зүүнгарын бүрэлдхүүнд орж байгаагүй Ижилийн торгууд нар 1771 онд Чинд дагаар ирснээс хойш ойрадууд Чин-Хасагийн харилцаан дахь бүр ч том асуудал болж хувирсан юм. Ижил мөрөн дахь нутгаасаа Зүүнгар дахь Чингийн хил хүртэл торгууд нар хасагийн довтолгоонд байнга өртөн туйлдаж олон хүн тулаанд эсхүл өлсгөлөнгөөр үхэж, бас нилээд нь хасагт олзлогджээ. “Торгууд нар нутаг буцсан нь”

⁴⁵ [bebek. purpu udu ishunde eigen sargan seme takaha bicibe. yargiyan tašan be fuhali baicara temgetu akū bime. amba gurun i albatu ojoro onggoi i baita. ne gubci hasak sa oci. enduringge ejen i gosin wen de dahafi. juwan udu aniya oho. dolotbai. bebek be asigan sargan obuhangge hono musede albatu oho amala i baita...aika jun gar i forgon i siden temgetu akū eigen sargan bihe sere emu gisun be memere. ini juwan emu aniya eigen sargan obuha niyalma be amasi bahaburakū oci. enduringge ejen i dorgi tulergi ahasi be emu adali bilume gosire ten i gūinde acanarakū seme gūimbime.] Барпин, ТТ 33.06.08. MaLFZZ 2272-033; 082-3206.

⁴⁶ Барпин, ТТ 33.04.08. MaLFZZ 2266-030; 082-1801.

⁴⁷ [ület. hasak gemu amba ejen i albatu. baime dosika ūlet sebe gemu bargiyafi.] Чингийн тал Атахайн эхнэр Умусуныг Ирид суусан ойрадад эрд гараагүй тул буцааж өгсөн бөгөөд энэ хэргээр жишиг болгон Хасагийн дунд жузийн хаан Аблайн хатан Күкэшийг Ирид Шотон хэмээх ойрад эрд гарсан тул буцааж өгөхгүй хэмээжээ. ТТ 27.02.03. MaLFZZ 1926-020; 062-0867.

Чингийн төрийн хувьд Энх-Амгалан, Найралт төв, Тэнгэрийн тэтгэсэн гурван хааны үеийг дамжин байж хэрэгжсэн нийт монгол угсаатныг нэгтгэн захирах эрмэлзлийн оргил байлаа. Энэ үйл явдлыг дурсгаж шүлэг зохиолгож, хөшөөний бичээс сийлүүлэн, Халуун голд зуны ордонд тансаг их найр үүсгэж, хожмын түүхчид Чингийн албан түүхийг баримтлан “Торгуудын буцсан”-ыг тайлбарлаж байв. Хасаг, Ойрад нарын хувьд бол энэ нь Чингийн төр Зүүнгарыг эзлэн дагуулахаас өмнө үүссэн олон зуунаар үргэлжилсэн хасаг ойрадын зөрчиллийн эцсийн цэг болсон аж. Хасаг-Ойрадын харилцааг зохицуулахаар оролдсоноор Чингийн тал өөрийн бий болгоогүй зөрчил тэмцэлд аяндаа татагдан оржээ. Торгууд-Хасагийн хоорондох зөрчлийн тухай би тавдугаар бүлэгт ярих тул энд өгүүлэхгүй харин өгүүллийн үлдсэн хагаст 1759-1771 оны хоорондох үед хамаарах Чингийн цэргээс зугтсан ба мөн хасагуудад олзлогдоогүй дүрвэгчдийн тухай өгүүлье. Эхлээд Таримын сав газар дахь уйгурын хотуудад очиж хоргодсон ойрад нарын тухай авч үзнэ. Чингийн төр тэдгээр ойрад боолуудыг уйгур нараас ихээхэн үнэ төлж худалдан аваад Хасагаас оргон ирсэн ойрадуудын хамт суулгаж байсан юм⁴⁸.

5. Уйгуруудын дундах Зүүнгарын дүрвэгчид

Уйгуруудад боолчлогдсон ойрадуудыг суллаж авах Чингийн шийдвэр нэг гэмт хэргийг мөрдөн шалгах явцад гарчээ. Хоёр ойрад боол буу аван уйгур эздээсээ оргохоор зэхэж байгаад баригдсан аж⁴⁹. Дэргэ хэмээх Чингийн түшмэл хэргийг байцаан тодруулж хаанд айлтгасан айлтгалдаа Зүүнгарыг мөхсөний сүүлээр олон ойрадуудыг уйгурууд олзлон авч боол болгосон байгааг мэдүүлжээ. Уйгурууд тэдгээр ойрад боолууддаа маш хэрцгий хандаж байсан агаад ажилд гаргахдаа хооронд нь холбон гинжилж өдөржин гинжтэй явуулдаг байсан нэг тохиолдлын талаар тэр айлтгалаас мэдэж болно. Ийм харгис нөхцөлд байсан учраас тэд байнга оргож босч байж. Дэргэ нар эдгээр босгуулууд очих газаргүй тул ууланд гарч махчинтай нийлэхээс болгоомжилж байгаагаа илэрхийлжээ⁵⁰.

Уйгурууд ойрадуудад ингэж хандаж байсан нь гайхах зүйл биш юм. 18-р зууны эхээр Зүүнгарын улс Таримын сав газрын Уйгур нутгийг дагуулан аваад жил бүр алба авч байсан тул Чингийн төр Зүүнгарын оронд засаг барих болсон

⁴⁸ Хасагийн гарт байсан ойрадууд бүгд оргож чадсан хэрэг биш бөгөөд хасагууд Чинд агт арилжиж торго авдаг шигээ байсхийгээд ойрад боолуудаа авчирж торгоор арилждаг байв. Нэг удаа Тэнгэрийн тэтгэсэн хаан Улиастайд хасагууд нэг ойрад хүнийг 10 лан мөнгөөр ө.х. Илим худалдах үнээс өндөр үнээр худалдаж байгааг мэдээд, хасаг нарыг Илим очуулж худалдуулахын тулд тэнд ойрад нарыг өндөр үнээр худалдаж авахыг тушаажээ. Manchu court letter edict, TT 29.01.08. Document number: 03-130-4-001.

⁴⁹ Дэргэгийн уг айлтгалыг олж чадсангүй харин эндээс эш татлаа: Юнгүй, TT 27.03.03. MaLFZZ 1932-019; 062-1850.

⁵⁰ Дэргэ, TT 26.12.18. MaLFZZ 1914-027; 061-2600.

ч уйгур, ойрад хоёрын хоорондох дайсагналцал арилаагүй хэвээр байв. Жишээ нь, Зүүнгар улс мөхөөд арваад жил өнгөрсөн хойно ч Чингийн төрөөс Яркандад суулгасан ойрад цэргүүд нутгийн уйгур хүн амтай харилцаа муутай байсан тул тэднийг татаж оронд сахар цэргүүд суулгаж байжээ⁵¹. Ойрад болон уйгурууд ямар учраас нэг дор байж болохгүй талаар Юнгүй яльгүй өөр саналтай байв. Үүнд,

"Өөлдийн амьдрал, хотон нараас угаас өөр бөлгөө. Хотонгийн сурталд мөн сурахгүй. Энэ угаас басхүү зүйл зүйлээр хашираан зовоон зарваас оргон зайлах зүйл тогтоож бүхий нь эдүгээ зохихыг үзэн биеийн худалдаа шагнаж золин Илимд илгээх нь маш нэг сайн хэрэг⁵²."

Хэбэй жанжин энэ хэргийг үзээд Чингийн түшмэдийг уйгурын боол болсон ойрадуудыг мөнгө төлж авах зарлиг буулгахыг хаанд айлтгасанд зөвшөөрчээ. Чингийн төр эдгээр суллагдсан ойрадуудыг Или, Үрүмчийн газар бусад ойрадуудтай цуг суулгахаар шийджээ. Энэ шийдвэрийг хүлээж аваад хэбэй жанжин нэг ойрад эрийг долоон лан, хүүхдүүдийг гурван лан мөнгөөр уйгуруудаас худалдаж авахыг тушаажээ⁵³. Алтышар буюу уйгурын зургаан хотын Хаким бек нарын төлөөлөгчид тус бүртээ өөрсдийн хотод байгаа ойрад нарыг эрэн сурвалжилж эзэн боол хоёр хоёул зөвшөөрсөн тохиолдолд мөнгөн

⁵¹ Шүхэдэгийн айлтгалд: "Кашгарт өөр хот барьж цэрэг суулгажээ. Ушийн хот хотон нарын суусан газраас маш хол. Яркандын газар болвоос цэрэг, хотон нэг хотод суужээ. Хотон нар угаас өөлд нараас аймой. Гурван жилийн хооронд нэлээд удмой. Харилцан амгалан үгүйг үгүй болгон чадахгүй" гэжээ. Шүхэдэ уйгур нартай ямар нэг хэрэг төвөг дэгдэхээс сэргийлж, Ярканд дахь нэг зуун ойрад цэргийг Уш хотод илгээхийг санал болгожээ.

⁵² [ület i banin. hoise se ci daci encu bime. hoise i tacihiyan de inu tacirakū. ere dade geli hacinggai akabume

adunggiyame takūrsaci. ukara jailara hacin toktofi bisirengge. te acara be tuwame beyei hūda šangnafi jolifi. ili de unggirengge umesi emu sain baita.] Юнгүй, ТТ 27.03.03. MaLFZZ 1932-019; 062-1850.

⁵³ Хэбэй жанжин Дэргэгийн айлтгалд нэг өөрчлөлт хийгээд баталжээ. Дэргэ том хүнд арван лан, хүүхдийн төлбөрт таван лан өгөхийг санал болгосон байв. Хэбэй жанжин үүнийг хэтэрхий их гэдгээ том хүнийг долоон лан, хүүхдийг гурван лангаар худалдаж авах албан үнэ тогтоожээ. Тэгэхдээ үүнээс урьд үүссэн нэг хэргийг үндэс болгосон байна. Үрүмчид сууж байсан ойрад нар төрөл садан нь дайны үеэр тэднээс салж Турфан дахь уйгуруудын боол болсныг мэдүүлж Чингийн засгаас тэдгээр ойрад нарыг уйгуруудаас төлбөр төлөн худалдаж аваад төрөл төрөгсөдтэй нийлүүлэн Үрүмчид суулгасан байна. Энэ хэбэй жанжины айлталыг Юнгүй, ТТ 27.03.03. MaLFZZ 1932-019; 062-1850.-аас эшлэв. Уйгур нарт заримдаа мөнгөөр заримдаа тэнгэ, пүл хэмээх Алтышарын мөнгөөр төлбөрийг өгч байв. Юнгүй, ТТ 27.06.07. MaLFZZ 1953-025; 063-2646. Заримдаа төлбөрийн нэг хэсгийг бэлэн мөнгөөр өгч үлдсэн хэсгийг нь татвараас хөнгөлөх маягаар тооцож байжээ. Жишээ нь Аксугийн бек нар 31 ойрад боолын төлбөрт 197 лан мөнгө авах ёстой (26 том хүн тус бүр нь 7 лан, 5 хүүхэд тус бүр нь 3 лан) байснаас 72 ланг нь өгч үлдсэн 125 ланг нь татвараас чөлөөлснөөр тооцжээ. Обоо, ТТ 27.05.01. MaLFZZ 1941-023; 062-3460. Хэрвээ уйгур нар татварын өргүй бол тэдэнд төлбөрийг-бүрэн олгож байв. Жишээ нь Хожомэнээр хэмээх уйгур татварын ямар нэг өргүй тул өргөсөн 4 ойрадын төлбөрт 16 лан (1 том хүн, 3 хүүхэд) өгчээ. Дасанга, ТТ 27.05.17. MaLFZZ 1943-026; 063-0218.

төлбөр өгч суллаж байв. Тэдэнд өргөн боломж олгосны хажуугаар ямарваа гэр бүлийг салгах юм уу эсвэл уйгур нартай гэр бүл болсон ойрадыг худалдаж авч болохгүй хэмээн зааварлажээ⁵⁴. Худалдаж авсан ойрадуудын дийлэнх нь Хаким бекүүдийн өөрсдийнх нь боол байсан бөгөөд тэдний ихэнх нь Тэнгэрийн тэтгэсний өгөөмөр хөлсөөр өөрсдийн ойрад боолуудаа худалдаж хялбар мөнгө олох сонирхолтой байв. Хэдийгээр Алтышаар дахь ойрад боолуудын ихэнх нь жирийн иргэдийн бус Хаким бекүүдийн өмч байсан байж болох боловч Алтышаар дахь нийт ойрадын тоо нь худалдаж аваад Илим илгээсэн ойрадуудаас илүү байсныг баримтууд харуулж байна. Олон ойрадууд Илийн байдал сайн юм уу муу эсэхийг мэдэхгүй байсан тул тийшээ очихоо эргэлзэж байв. Зарим нь аян замын ая даахгүй өвчтэй байхад нөгөө нэг хэсэг нь уйгур нартай сууж гэр бүл үр хүүхдээсээ салахыг хүссэнгүй.⁵⁵ Энэ бодлогын дагуу худалдаж авсан ойрадуудын нийт тоог Хүснэг 2-оос үзнэ үү.

Хэдийгээр дээрх хүснэгтэд үзүүлсэнчлэн нилээд ойрадууд уйгуруудаас худалдаж бавсан боловч тэдний ихэнх нь ямар нэг ажил хийх буюу хүүхэд төрүүлэх наснаас хэтэрсэн хөгшин эмэгтэйчүүд байжээ. Уйгурууд ажиллах хүчин болсон залуу ойрад боолуудаа худалдсангүй. Агуй үүнээс хойш зөвхөн залуу ойрадуудыг худалда авахаар тогтоосон бөгөөд гэрлэх насны ойрад эмэгтэйчүүдийг “хэдий олон худалдаж авна төдий чинээ сайн” хэмээн тэдгээрийг худалдаж авахыг голчилжээ.⁵⁶ Агуй ганц бие ойрад бүсгүйчүүдийн тоог нэмэгдүүлэх гэсэн нь Или дахь ойрадууд ялангуяа Хасагаас зугтаж ирсэн ойрад нарын дунд хүйсийн тэнцвэргүй байдал үүсээд байсантай холбоотой юм. Миншүйгийн айлтгалаас үзвэл зургаан зуугаас илүү ойрад эрчүүд Илим эхнэр олж чадахгүй байжээ. Энэ байдлыг Миншүй “Олон зуун эрс ямар ч эм авах боломжгүй байна. Гэр бүл зохиож чадахгүй байх нь урт хугацааны арга биш” хэмээн бичжээ. Миншүйгийн айлтгаснаар энэ хүйсийн тэнцвэргүй

⁵⁴ Агуй, ТТ 27.06.22. MaLFZZ 1955-014; 063-3036. Гол асуудал нь ойрадууд бүгд нэг дор сууж байвч гэр бүл дотроо өөр өөр эзэдтэй байсанд оршино. Тэдний зарим нь боолуудаа худалдах сонирхолгүй байснаас гэр бүлийг салгах байдалд ороод байв.

⁵⁵ Сүчэн, ТТ 27.09.25. MaLFZZ 1973-002; 064-2835. Үүний эсрэг Алтышаар дахь ойрадын тоо тийм ч их байгаагүй гэсэн мэдээ ч бас байна. Кашгарын хаким бек Гайдамет, “Манай Кашгар. Енгисарын газар хотонгийн захыг тогтоожээ. Зүүнгарын нутгаас алсалсан нь хол тул нааш босч ирсэн өөлд угаас ховор бөлгөө.” [Meni kasigar. inggazar i ba.hoise i dubei jecen be iliha. jun gar i nukte ci sindalabuhangge goro ofi. ebsi ukaka jihe ület se daci komso bihe.] Наситун, ТТ 28.10.12. MaLFZZ 2057-039; 069-0248.

⁵⁶ Агуй, ТТ 27.03.24. MaLFZZ 1935-011; 062-2312. Тэдний дунд энэ бодлогыг далимдуулан Илим үнэгүй хүргэгдсэн уйгурууд бас байв. Жишээ нь Алтышаараас худалдаж авсан хүмүүсийн дунд 17 уйгур хүн байсан бөгөөд тэд өөрийн бекүүдэд өөрсдийгөө ойрад хүн хэмээн худлаа хэлснийг илрүүлжээ. Тэднийг уйгур гэдгийг сайн мэдэж чадах бек нар юунд тэдний үгэнд итгэсэн бэ гэдэг сонирхол татаж байна. Бодвол мөнгөн төлбөрийн асуудал тэднийг нүдээ анихад хүргэсэн болов уу. Эдгээр уйгуруудыг ойрадын хамт бус Илим байсан уйгуруудын дунд суулгажээ. Айлач хэмээх ойрад эмэгтэйн уйгур эзэн нь мөнгөн төлбөр авахгүй хэмээсэн тул оргон ирснийг Илим суулгасан байна. Агуй, ТТ 27.06.22. MaLFZZ 1955-022; 063-3078.

байдал ойрын хугацаанд байгалийн жамаар нөхөгдөх бололцоогүй гэр бүлтэй ойрад нарын цөөн хэд нь л гэрлэх насанд дөхсөн охидтой байсан тул Миншүй энэ байдлыг шийдвэрлэх хоёр санал гаргажээ. Нэгд, Алтышаарт залуу ойрад охид бүсгүйчүүд мөн л байсаар байгаа гэж үзээд тэндэхийн уйгур нараас ойрад бүсгүйчүүдийг үргэлжлэн худалдан авахыг дурдав. “Уйгур нар ойрад бүсгүйчүүдийг зарцлахыг хичээн тэднээс салж бидэнд илгээхийг хичээсэнгүй”.⁵⁷ Миншүйгийн хоёрдахь санал нь “Ногоон тугийн” хятад цэрэгт боол болгосон ойрад бүсгүйчүүдийг худалдаж авах байв.

“Сонсвоос, дотор газрын ногоон тугийн ард урьд олсон олзолсон жич тэдний худалдан авсан өөлд эмс бас үлэмж. Нэгэнт эм болгон авснаас

Хүснэгт 2: Уйгураас худалдаж авсан ойрадууд⁵⁸

Төлбөр төлөн худалдаж авсан ойрад нарын тоо	Төлбөрт өгсөн мөнгөний дүн (лангаар)	Хаанаас	Эшлэл
112	736	Пижан	Дэргэ, ТТ 27.02.22. MaLFZZ 062-0982
7	45	Кашгар	Илэту, ТТ 27.03.26. MaLFZZ 062-2384.
17	103	Кашгар	Юнгүй, ТТ 27.04.17. MaLFZZ 062-3262.
7	49	Уш	Юнгин, ТТ 27.04.22. MaLFZZ 062-3300.
31	197	Аксу	Обоо, ТТ 27.05.01. MaLFZZ 062-3460.
71	465	Турфан	Дэргэ, ТТ 27.05.08. MaLFZZ 062-3453.
27	185	Ярканд	Синжү, ТТ 27.05.02. MaLFZZ 063-0167.
2	14	Хотан	Дээр эшилсэн айлтгал.
4	16	Корла	Дасанга, ТТ 27.05.17. MaLFZZ 063-0218.
4	28*	Ярканд	Обоо, ТТ 27.10.08. MaLFZZ 065-0078.
4	28*	Куча	Обоо, ТТ 28.02.28. MaLFZZ 066-2360.
286	1866		

⁵⁷ Миншүй, ТТ 28.06.25. MaLFZZ 2039-032; 067-3114.

⁵⁸ Төлбөрийн мөнгөний хэмжээ баримтуудад ихэвчлэн бичигсдэн байсан боловч * тэмдэг тавьсан хэсгийг би өөрөө бодож гаргасан болно.

гадна явдлын сувилах гэрт зарах эмс охид бас буй хэмээмой. Үүнд залууг нь сонгон зохихыг үзэн баахан худалдаа өгөн зольж, ташрамд Илип хүргэн иххэн өөлдөд эм нийлүүлэн үлсэн өөлд нарт хойно цахар өөлд нарын эм хүүхэд өсөн жич дараа дараагаар хүргэх болвоос нийт өөлд нарын санаа нэн халуухан болмой⁵⁹.”

Тэнгэрийн тэтгэсэн хаан Миншүйгийн айлтгалыг зөвшөөрөөд, “зарим улс эмгүй байх аваас жаргалгүй болмой” хэмээжээ. Тэнгэрийн тэтгэсэн хаан Миншүйгийн гэр бүл болсон ойрад эхнэрүүдийг Илип илгээхгүй гэснийг зөвшөөрсөнгүй, “Ойрад Хятад хоёр хоорондоо тохирохгүй” хэмээгээд өөрсдөө хүсвэл ойрад эм авсан хятадуудыг мөнгөн төлбөр аваад эмсээ тушаан Илип илгээхийг зарлиг болжээ⁶⁰. Бодот байдал дээр мөнгөн төлбөр өгч худалдан авсан ойрад бүсгүйчүүд нь хүний эхнэр буюу боол болсон ойрад эмэгтэйчүүдийн өчүүхэн хувийг эзэлж байв. Жишээ нь Хамид байсан ногоон тугийн хятад цэргийн тэнд байсан 45 ойрад эхнэрээс 14-ийг нь л мөнгөн төлбөрөөр худалдан авчээ. Үлдсэн 31 эмэгтэйчүүдээс 5 нь уйгур нөхөртэй, хоёр нь хэтэрхий бага (9-өөс доош настай), 22 нь хэтэрхий хөгшин (50-иас дээш настай), 2 нь 40 гаруй настай хэдий ч хэдийн үр тогтоох наснаас хэтэрсэн тул ахин гэрлэх боломжгүй байжээ⁶¹.

Ногоон тугийн цэрэг болон уйгур нараас ойрадуудыг худалдаж авахаас гадна Чингийн засаг Уйгур нутагт арай чамай сууж байсан ойрадуудад анхаарал тавив. Жишээ нь Пижангийн ойролцоох уйгур тосгоны гадна гэр барин лам дээл өмсөн судар уншиж суусан нэг нь 57, нөгөө нь 52 настай хоёр ойрад эмэгтэй байв. Эр нөхрүүдээ үхсэний хойно тэд дайны самууны үеэр Донжибугийн цэргийн дагалдан Пижанд ирсэн гэжээ. Тэднийг Үрүмчид илгээж төрөл төрөгсдийнх нь хамт суулгажээ.⁶² Чингийн төр найман хошууны цэрэгт олзлогдож тэдний эм болсон ойрад бүсгүйчүүдийг олж авах гэж нилээд чармайлт гаргасан байна. Зүүнгарт суулгасан Чингийн цэргийн ихэнх нь тэнд түр сууж байсан бөгөөд эргүүлэн татагдахдаа тэдгээр ойрад бүсгүйчүүдийг

⁵⁹ [donjici, dorgi ba i niowanggiyan turun i urse. ongolo baha oljilaha. jai ceni udame gaiha ület hehesi kemuni labdu. emgeri sargan obume gaihangge ci tulgiyen bai eršeme boode takürara hehesi. sargan jui kemuni bi sembi. ede se asigan ningge. be sonjome. acarä be tuwame majige hūda bume joolifi. ildun de ili de benjibufi. se ambakan ület de sargan acabume. funcche ület sede. amala cahar ület sei sargan juse mutufi. jai siran siran i isibure oci. gubci ület sei günin ele halukan ombime.] дээр эшилсэн айлтгал.

⁶⁰ Тэнгэрийн тэтгэсний зарлигийг Дэргэ, ТТ 28.09.15. MaLFZZ 2053-020; 068-2808.-ээс эшлэв. Уг эхийг нь олж чадсангүй.

⁶¹ Самбуу, ТТ 28.09.16. MaLFZZ 2052-030; 068-2622.

⁶² ТТ 27.05.08. MaLFZZ 1941-020; 062-3450.

амь зуух ямар ч аргагүй орхин явж байжээ. Тэнгэрийн тэтгэсэн хаанд Яркандад түр байрлаж байсан солон цэргүүд хоёр ойрад, хоёр уйгур хүүхнийг эм болгон аваад тэндээс татагдахдаа тэднийг орхин явсныг айлтгасанд, энэ мэт явдлыг хориглосон дараах зарлигийг буулгажээ.

Хүснэгт 3: Ногоон тугийн цэрэг болон уйгур нараас худалдан авсан ойрад эмэгтэйчүүд.

Мөнгөн төлбөр өгч худалдан авсан ойрад эмэгтэйчүүдийн тоо	Хаана	Эшилсэн айлтгал
6	Кашгар	Наситун, ТТ 28.10.12. MaLFZZ 069-0248
21	Уш	Сүчэнг, ТТ 28.10.08. MaLFZZ 069-0054
2	Куча	Обоо, ТТ 28.10.21. MaLFZZ 069-0439
11	Турфан	Дэргэ, ТТ 28.09.15. MaLFZZ 068-2808
14	Хами [Ногоон тугийн цэрэг]	Самбуу, ТТ 28.09.16. MaLFZZ 068-2622
73	Аксу, Сайрам, Бай	Хаймин, ТТ 28.09.22. MaLFZZ 068-3170
47	Ганьсу [Ногоон тугийн цэрэг]	Сахан, ТТ 29.02.22. MaLFZZ 070-0591
174		

“Солон нарын авсан хотон, өөлд эм Сэбтэн, Кэтэши, Султанбэби, Халча цөм олзлон авсан нь тэнд агуулваас болохгүй ялдар цөм Илип илгээж өөлд нарт эм болгон шагнатугай. Урьд цэрэг ороход Зүүнгарын ард муу харгис урвах хэцүү тул тэнд олзны эмийг цаазалсангүй бөлгөө. Эдүгээ Зүүнгар Хотонгийн газрыг төвшитгөн тогтоож олон газарт цөм цэрэг суулгасан. Хэрэв басхүү цэрэг орох цагийн адил цэрэг ардын дураар дэмий ичгүүргүй хэрэг өдүүлвээс хэрхэвч хэмээн болохгүй. Зүй нь ноцогдсоныг үзэж хүндээр ял хэлэлцвээс зохимой⁶³.”

⁶³ [solon sei werihe hoise. ilet hehe sebtен. ketesi. sultanbebi. halca gemu daci oljilame gajihangge. tubade bibuci oiorakū. ildun de gemu ili de unggifi. ilet sede sargan obume šangnakini. neneme cooha dosire de jun gar i urse che oshon ubašara mangga ofi. tuttu olji hehe be fafulahakū bihe. te jun gar hoise i babe necihiyeme toktobufi. geren bade gemu cooha tebuhe. aika kemuni cooha dosire forgon i

Солон цэргүүдийн хаяж явсан ойрад эмэгтэйчүүдийг бас олж Илид илгээн ойрад нартай гэрлүүлжээ⁶⁴. Ойрад эхнэр авсан цэргүүдийн эхнэрийг үлдээж цэргүүд дахин ойрад эхнэр авахыг хориглосон байна. Зүүнгар эсвэл Уйгур нутагт байсан цэргүүд буцан татагдах болвол ойрад эхнэрээ аван шинэ газар очих эсвэл үлдээж явахыг шийдэх ёстой байв. Чингийн түшмэд шинэ газар очсон тэдгээр ойрад эхнэрүүд нутгаа санан оргож босч болзошгүй хэмээн сэрэмжилж байжээ⁶⁵. Хэрэв эхнэр нь Зүүнгарт үлдвэл Илид илгээж ойрад нарт эм болгон өгч байв. Жишээ нь Гожимбуу хэмээх Чингийн цэрэг буцан татагдахдаа Санжин хэмээх ойрад эхнэрээ Илид илгээх ёстой болжээ⁶⁶.

Хүснэгт 3-аас харвал, Или дахь ганц бие ойрад эрчүүдэд ойрад эхнэр худалдаж авч өгөх гэсэн Чингийн оролдлого ердөө хоёр зуу гаруй бүсгүйчүүдээр хязгаарлагдсан нь илт дутуу байсан юм. Тэнгэрийн тэтгэсний 29-р онд Чингийн төрөөс Цахар найман хошууны эмэгтэйчүүдийг худалдан авч Илид хүргэн ойрад эрчүүдэд өгөх хөтөлбөр хэрэгжүүлжээ. Хошууны болон боол гэсэн хоёр өөр бүлгийн эмэгтэйчүүд байсан бөгөөд харилцан адилгүй үнээр худалдаж авч байв. Тэдэнд бүгдэд нь арав арван лан замын зардалд өгсөн бөгөөд боол бүсгүйчүүдийн эздэд эрд гараагүй охины оронд 10 лан, бэлэвсэн эмийн оронд 8 лан мөнгө өгсөн ажээ. Нийт эмэгтэйчүүдийн тоо болон тэдний оронд өгсөн мөнгөн төлбөрийг Хүснэгт 4-т илэрхийлэв⁶⁷.

Доорх хүснэгтээс үзэхүл сонгогдсон 420 эмэгтэйчүүдэд Чингийн сангаас 6612 лан мөнгөний зардал гаргасан бөгөөд энэ нь нэг эмэгтэйд 15.75 лан мөнгө зарцуулсан хэрэг болно. Энэ нь уйгуруудаас нэг бүрийг нь 7 лангаар худалдаж авч байсан эмэгтэйчүүдээс хоёр дахин үнэтэй байна гэсэн үг юм. Ийм хол газар ийм их зардал гарган эдгээр бүсгүйчүүдийг илгээх Чингийн эрмэлзэл нь Илийн ойрадуудыг гэр бүлийн талаар тайван байлгахыг хичнээн чухалчлан үзэж байсныг харуулна. 420 эмэгтэйчүүдээс нилээдгүй нь Или хүрэх урт удаан аяныг тэсвэрлэсэнгүй, 14 нь Үрүмчи хүрэх замд нас барж, 28 нь Үрүмчээс Илид хүрэх замд нас баржээ. Илид хүрсэн цахар эмэгтэйчүүдээс гучин нэг нь амь голтой арай гэж хүрснийг гэр бүл болох боломжгүй хэмээн үзэж тэнд суулгасан Цахар хошуунд оруулан суулгажээ. Ингээд Илид ирсэн 378 эмэгтэйчүүдээс 347 нь л ойрад эрчүүдтэй гэрлэсэнээр тэдний нэг бүрийн үнэ нь 19 лан болсон байна. Тэдгээр цахар бүсгүйчүүдийг ойрад нөхрүүдтэй нь

adali cooha ursei cihai balai derakū baita yabuci. tere ainaha seme oiorakū. giyan i nambuha be tuwame ujeleme weile araci acambi.] Элгингэ, ТТ 29.02.20. MaLFZZ 2077-002; 070-0829.

⁶⁴ Жишээ нь Жаргал, Эргэжав, Цэрэнжав хэмээх гурван ойрад эмийг солоон цэргүүд Аксуд хаян явсан байжээ. Тэднийг Илид илгээж ойрад нарт эм болгон өгсөн байна. ТТ 28.08.26. MaLFZZ 2050-029; 068-2147.

⁶⁵ Баянтахан, ТТ 29.03.09. MaLFZZ 2079-037; 070-1323.

⁶⁶ Элгингэ, ТТ 29.05.09. MaLFZZ 2089-024; 070-3347.

⁶⁷ Барпин, ТТ 29.06.27. MaLFZZ 2091-021; 071-0199.

танилцуулахын тулд Чингийн түшмэд Хасагаас түрүүнд дагаар орсон нь түрүүлж сонгох эрхтэйгээр уулзуулсан байна⁶⁸.

Хүснэгт 4: Цахар эмэгтэйчүүдийг сонгосон нь

Эмэгтэйчүүдийн төрөл	Тоо	Замын зардал	Мөнгөн төлбөр	Нийт төлсөн мөнгөн дүн
Боол охид	174	$174 \times 10 = 1740$	$174 \times 10 = 1740$	3480
Бэлэвсэн боол эмэгтэйчүүд	84	$84 \times 10 = 840$	$84 \times 8 = 672$	1512
Найман хошууны охид	80	$80 \times 10 = 800$	Үгүй	800
Найман хошууны бэлэвсэн эмс	82	$82 \times 10 = 820$	Үгүй	820
Нийт	420	4200 лан	2412 лан	6612 лан

6. Торгуудын дунд байсан Зүүнгарын дүрвэгчид

Чингийн цэрэг Зүүнгарыг эзэлснээс хэдэн мянган ойрадууд баруун зүг Ижил мөрний Торгуудын зүг зугтан очжээ. Тэдний ихэнх нь (гэвч бүгд бус) Зүүнгарын Шэрэн хэмээх ноёны албат байв. Эдгээр зүүнгарын дүрвэгчдийг Ижил мөрнөөс торгууд нарын хамтаар буцаж ирэхэд тэднийг угтаж авсан Чингийн түшмэд торгуудаас илүү сэжиглэн хандаж байсан тул тэднийг Или дахь Ойрадын найман хошуунд Хасагаас зугтан ирсэн ойрадуудын хамт суулгажээ. Үлдсэн торгууд нарыг дөрвөдийн (Зүүнгарыг мөхөхөөс өмнө Чинд дагасан ойрад аймаг) адил Ойрад найман хошуунаас илүү эрхтэй засаг захиргааны хуваарьт оруулжээ. Шэрэнгийн зугтсан болон Зүүнгарт эргэж ирсэн тухай би тавдугаар бүлэгт тодорхой авч үзнэ. Энд би Шэрэнтэй хамт буцаж ирсэн Зүүнгарын дүрвэгчдийн нийт тоог хүснэгтээр үзүүлье.⁶⁹

⁶⁸ Миншуй, ТТ 29.12.25. MaLFZZ 2122-026; 2816-072.

⁶⁹ Шүхэдэ, ТТ 36.08.14. MaLFZZ 2436-044; 093-2580

Хүснэгт 5a: Ойрад найман хошууны дээд гурван хошуунд хуваан оруулсан Зүүнгарын дүрвэгчид

Отог	Өрхийн тоо	Хүний тоо
Киргис	32	140
Дөрвөд	12	57
Холбос	3	17
Көбүн ноёд	31	145
Орган Жирган	63	257
Обид	129	463
Дэлэгэд	27	130
Тарвагачин	25	120
Хойд	10	33
Эркэтэн	25	97
Мянгад	3	23
Бүгд	360	1482

Хүснэгт 5b: Ойрад найман хошууны доод таван хошуунд суулгасан Зүүнгарын дүрвэгчид.

Отог	Өрхийн тоо	Хүний тоо
Бүкүс	94	390
Бардамууд	42	189
Доголод	41	163
Олондай	54	272
Гимбу жас	27	104
Лабарма жас	7	32
Цоохор	8	45
Галзуд	10	49
Зуутраг	10	60
Күрүд	11	50
Харчин	66	285
Төмөрч уруд	19	65
Алтач	3	18
Бүкүнүд	7	41
Түйсүлэн жас	40	163
Хошууд	9	53
Уруд	5	18
Хөтөчнэр	25	94
Доод хошуунд орогсдын нийт тоо	478	2091
Найман хошуунд орогсод бүгд	838	3573

6.Зүүнгарын дүрвэгчид: Коканд, Энэтхэг, Афганистан

Багахан хэсэг ойрад дүрвэгчид Чингийн цэрэг Зүүнгарыг эзлэн дагуулсны сүүлээр нилээд алсын Коканд, Афганистан бүр Энэтхэгт хүрсэн байна. Кокандад хүрсэн эдгээр ойрадын ихэнх нь уул нь хасаг, хиргисүүдэд баригдаж боол болон худалдагдсан улс ажээ⁷⁰. Тэнгэрийн тэтгэсний 29-р оны 7 сард, Чингийн хилд Ферганы хөндий дэх Маргилан хотоос оргосон таван ойрад хүн орж иржээ. Тэдний нэг Баран хэмээгч өөрийгөө Тэнгэрийн тэтгэсний 20-р онд хиргисүүдэд баригдаж Ферганы хөндий дэх Кокандын өөр нэг хот Наманганд боол болон худалдагдсан хэмээн өчсөн бөгөөд тэрбээр тэндээ таван жил болоод Маргилан руу оргож тэндээ бусад ойрад нартай нийлсэн хэмээн өчсөн бол нөгөө хэд нь уул нь хиргисүүдэд баригдаж Маргилан хотод боол болон худалдагдсан хүмүүс байв. Эдгээр ойрадуудын өчгөөс үзвэл тэндэхийн захирагч Рисули бек гэгч Маргиланы ойр бэхэлсэн хот байгуулж 200 гаруй ойрад цэрэг суулгасан бөгөөд Кокандын захирагч Эрдэни бек өөрөө 1000 ойрад цэрэгтэй байжээ. Гэр бүлгүй ойрад цэргүүдэд эхнэр өгч, хоол хүнс, зэвсэг хувцас хунараар хангаж, Кокандын цэрэг дайнд мордоход, эдгээр ойрадууд тагнуулын анги болон явж дайнаас буцахад ар талыг нь хамгаалах үүрэг хүлээнэ. Нэг өдөр тэд Чингийн цэрэг Кокандыг дайлаар ирэх гэж байна гэдэг яриаг олж сонсчээ. Эрдэни бек Рисули бект: *“Эдүгээ дотор газрын цэрэг Кокандад ирнэ хэмээмой. Чиний Маргиланд бүхий ойрад нар ер нь даруй сэжигтэй. Дотор газрын цэрэг ирвээс тэд эрхгүй даган одмой. Урьдаар тэднийг барьваас сайн.”* хэмээн ярьжээ⁷¹. Үүнийг сонссон мань таван ойрад эхнэрүүдээ хаян оргосон байна. Чингийн түшмэд тэдний ярианд итгэсэнгүй хэдэн уйгурыг худалдаачин маягаар илгээсэн нь тэдний хэлсэн ярьсан үнэн болохыг баталж иржээ⁷². Шүхэдэ бас өөр хэргийн учирт, Кокандад ойрадууд байгаа талаар айлтгаж байв. Түүний айлтгалд: *“Кокандын худалдааны хотон Кашгар, Яркандын зэрэг газарт тасралгүй явмой. Тэнд бүхий өөлд нар хотонгийн хотод өөлд цэрэг суусныг сонсож сэмээр даган ирэхийг үгүй болгон чадахгүй”* хэмээсэн байна⁷³. Тэнгэрийн тэтгэсэн хаан Шүхэдэ-гийн саналыг зөвшөөрч Кокандаас дагаар ирэх ойрадуудыг Хасагаас дагаар ирэх ойрадын нэгэн адил Илим суулгахыг зарлиг болжээ.

⁷⁰ Наситун, ТТ 29.04.21. MaLFZZ 2086-001; 0702667

⁷¹ [te dorgi ba i cooha hoohan de jimbi sembi. sini margalang de bisire ület se. an i ucuri. uthai kenehunjecuke.dorgi ba i cooha jici. ce urunaku dahame genembi. neneme cembe jafaci sain seme.] Nasitun, QL29.08.07. MaLFZZ 2103-035; 071-2682.

⁷² ТТ 29.10.26. MaLFZZ 2116-031; 072-1473.

⁷³ [hoohan i hūдай hoise kasigar. yerkiyang ni jergi bade lakcan akū yabumbi. tubade bisire ület se hoise hoton de ület cooha tehe be donjifi. jendu baimе jidere be akū obume muterakū.] Шүхэдэ, ТТ 34.07.14. MaLFZZ 2325-015; 086-0926. Шүхэдэ энэ айлтгалыг ямар учраас бичсэн нь тодорхойгүй байна. Энэ айлтгалыг бичихийн өмнө хойно Кокандаас дагаар ирэх ойрадын талаар дурдсан ямар нэг юм үгүй.

Сурвалжид Кокандаас бүр илүү хол Афганистан, Ладак, Кашмир, Энэтхэг хүрсэн ойрадуудын тухай ховор ч гэсэн мэдээ тохиолдож байна. Жишээ нь Шириба Жүнгни өөрийн үеэл Дашцэрэнгийн хамт Ярканд дахь Чингийн түшмэдэд Ладакаас ирж дагаар оржээ. Тэднийг арван жилийн урьд хасагууд олзолж авсанд тэднээс оргон Энэтхэг (*Industan*) орж, тэнд байхдаа Чингийн цэрэг Илийн газрыг эзэлж ойрад нарыг нутагт нь суулгаж байгаа тухай сонсоод Энэтхэгээс нутагтаа буцахаар шийджээ. Эхлээд Кашмир орж тэндээсээ Ладак, Яркандыг холбосон уулын худалдааны замаар явж ирснийг Ирид хүргэн бусад ойрад нартай хамт суулгасан байна⁷⁴. Өөр нэгэн Нүрмэд хэмээх ойрад хүнийг Бадахшаны захирагч Султан шах Чин гүрэнд илгээснийг Чингийн түшмэл Кичэнгэ: “Энэ гэгч урьд Яркандын Хожжа Жиханыг дагалдан урваж манай цэргийг довтолсон хүн. Агуулваас болохгүй, цаазаар авбал зохих мэт” гэснийг Тэнгэрийн тэтгэсэн хаан: “Өөлд Нүрмэд гэгч огт хэрэглэх хүн бус. Урьд Хожжа Жиханыг нийлэн манай цэргийг довтолсон нь цөм өнгөрсөн явдал. Цаазаар аваачих хэрэггүй.” хэмээжээ⁷⁵. Энэ дотроос хамгийн сонирхолтой түүх Харагай хэмээх Зүүнгарын дүрвэгчийнх байж магадгүй юм. Харагай, Түвшин хэмээх ойрад эхнэрийнхээ хамтаар Яркандад худалдааны жинтэй цуг ирж Чингийн түшмэдэд дагажээ⁷⁶. Тэнгэрийн тэтгэсэн хаан Ярканд хүртэл Харагайн явж өнгөрсөн олон улсын тухай өөрийн биеэр асууж сонсохоор түүнийг Бээжинд ирэхийг тушаасан байна⁷⁷. Харагайн өчиг, нэг дүрвэгч хүний амьдралыг тодорхой харуулж байх тул энд бүтнээр нь эшлэе.

“Би энэ жил хорин есөн настай. Өөлдийн Доголод отогийн зайсан Басангийн харьяат хүн. Зүүнгар Хасаг харилцан дайн дэгдэхэд миний эцэг Шарав, миний эх, дөрвөн дүү цөм хасагт уулгалагдан баригдсан. Миний арван хоёртойд миний эцэг Шарав намайг авч Хасагаас оргон гарч Буруд газарт хүрэв. Миний эцэг үгүй болсон хойно, намайг арван тавтайд их цэрэг ороход Бурхануддин Чунбагаш Бурудаас манай өөлд хөвүүн хоёр охин хоёрыг булаан Бадахшанд аваачиж Хожомнидзарт өгөв. Энд өөлд охин Түвшинийг надад эм болгон өгөв. Хойно

⁷⁴ Элгэнгэ, ТТ 31.03.19. MaLFZZ 2184-029.2; 076-3437.

⁷⁵ ТТ 35.02.09. MaLFZZ 2371-042; 089-0137. Тэнгэрийн тэтгэсэн хааны түүнийг өршөөсөн үнэн учир нь өөрийн үргэлж сонирхон анхаарч байсан Бадахшан орны тухай өөрийн биеэр байцаан мэдэж авахад оршиж байсан байж магадгүй. Нүрмэдийг тэр даруй Бээжинд илгээсэн бөгөөд их журганд түүнийг байцаасан тэмдэглэлийг Фүхэн, ТТ 35.05.11. MaLFZZ 2369-011; 088-3085-д үзэж болно.

⁷⁶ Жингэри, ТТ 34.05.26. MaLFZZ 2319-033; 085-3609.

⁷⁷ Энэ зарлигийг Жингэри, ТТ 34.08.03. MaLFZZ 2337-018; 086-2975.-аас эшлэв. Tibet хэмээх манж үгийг би Ладак хэмээн орчуулав. Ер нь tibet гэх нь “Төвд”-ийг заадаг боловч Др. Мэтью Моска энэ үг нь Ладакийг заадаг байсан хэмээн хэлсэн билээ. Харагайн явсан замыг газрын зураг дээр зурж үзвэл tibet гэх нь энэ тохиолдолд Ладакийг хэлж байгаа нь ойлгомжтой байна.

Хожомнидзар манай эхнэр нөхрийг зугтсугай хэмээх үгийг сонсож би эхнэрээ аван Бадахшанаас Күндүзд оргон одож Күндүзийн тэргүүлсэн хүн Мидзараб бекийг даган хоёр жил суув. Күндүзийн газар Бадахшанаас алсалсан нь дөрвөн өдрийн зайтай буй. Бадахшаны баруун хойт этгээдэд буй. Күндүзийн ард тариа тарин амьдармой. Морь ховор хонь үлэмж. Хойно Афганистаны тэргүүлсэн хүн Ахмад шах түүний доорхи Шабсан бекийг зарж Күндүзд ирж морь мал тариа зэрэг алба авахад Мидзарабын байгаа мал, манай эхнэр нөхрийг холин Афганистаны Шабсан бект өгч аваачуулав. Би Шабсангийн дэргэд хоёр жил зургаан сар зарагдав. Афганистаны газар Күндүзийн баруун өмнө захад буй. Күндүзээс алсалсан нь арван хоёр өдрийн зайтай буй. Афганистаны хүн үлэмж. Үг бардам, уулгалах булаахад бахтай. Морь ховор хонь их. Мөн тариа тарин амьдармой. Жич Лахорын газар онц халуун. Афганистаны зүүн урд захад буй. Нутаглан явбаас тавин өдөрт хүрмой. Афганистаны хүн жил бүр Лахорын газарт өвлийг өнгөрүүлэхээр одмой. Манай эхнэр нөхөр Шабсанг даган одсон билээ. Хойтон жил нь хавар цагт Афганы хүн хойш буцахад би эмийг аван оргон зайлж Лахор газарт хоцорч хоёр сар гуйланчлан явав. Тэнд Лахороос Кашмирт одов. Кашмирын тэргүүлсэн хүний нэр Нуртангха. Тэндхийн ард тариа тарин амьдармой. Морь мал үлэмж үгүй боловч доорд ард хангалуун. Би даруй Кашмирын газарт суув. Кашгарын худалдааны хотон Ниясбект түшин таван жил илүү суув. Кашмирын газар, Лахорын зүүн хойт этгээдэд буй. Арван нэгэн өдрийн зайтай. Би Кашмирт байхад худалдаачин хотонгоос Их богд эзэн Зүүнгар Хотон бүгд газрыг бүрэн төвшитгөн тогтоож, манай өөлд нар тус тус олж жарган цэнгэлдэн эрмүй хэмээснийг сонсч өөрийн эм, охиныг авч жаахан хүнс баглан зүүн хойт зүг долоон өдөр явж Ладакийн газарт хүрч манай Илийн өөлд нар Ярканд ... жарган цэнгэн амьдрахыг лавт мэдсэн тул Ладакийн тэргүүлсэн хүн Ялбуд эрж, Ялбу надад нэг морь арав илүү өдрийн хүнсний хувь өгч би эм Түвшин, охин Жинатыг авч нааш эрэн ирэв. Замд худалдаачин хотон Абдурман нарыг учирж тэднийг даган хамт Яркандад хүрэв.⁷⁸

⁷⁸ [bi ere aniya orin uyun se. ület dogolot otok i jaisang basang ni harranga niyalma. jun gar hasak ishunde dain dekdere de. mini ama sirab. mini eniye. duin deo. gemu hasak de durifi gamabuha. bi

Харагайг энэ мэт өчиглөсний сүүлээр Илим буцаан илгээж эхнэр охиных нь хамт суулгажээ.

7. Угсаатны ухамсрын хувиралт – Ойрад ба хасагууд

Ийнхүү бид Зүүнгарын улс мөхсөний сүүлээр ойрадууд олноороо дүрвэж ойсныг үзлээ. Заримыг нь Чингийн цэрэг хядаж, нэг хэсгийг нь хасагууд олзолж, нөгөө хэсэг нь ууланд зэрлэг ан агнаж амь зуун, бас нэг хэсэг нь Чингийн цэргийн боол болж, нилээдгүй нь торгууд нарын дэргэд одож, үлдсэн нь Алтышаар, Коканд бүр Энэтхэг, Афганистанд ч хүрсэн байна. Үүний хажуугаар ойж зугтсангүй, алуулж хядагдсангүй хуучин Зүүнгарын харьяатууд бас байсан нь ердөө нутгийн иргэдэд уусч хайлчихсан аж. Жишээ болгон Тогтош хэмээх арван дөрвөн настай хиргис хэлтэй хүүгийн түүхийг авч үзье. Тэр бол Бай хотын гаднах нэгэн уйгур худалдаачны гэрт зарагдах зарц байсан бөгөөд жирийн нэг зарц бус гэдгээ өөрөө ч мэдсэнгүй. Түүний жинхэнэ нэр нь Мүндүбаяр бөгөөд өвгө авга нь болох Зүүнгарын хуучин удирдагч Цэвээнравданы төрөл садны сүүлчийн эрэгтэй төлөөлөгчдийн нэг байв. Түүний бага байхад нь Зүүнгарын ноёдын дотоодын самуунд эцэг нь алагдаж, тэр бол тэднээс амьд үлдсэн цорын ганц хүн нь байжээ⁷⁹. Түүний авга эгч нь

juwan juwe se de. mini ama sirab. mimbe gaifi. hasak ci ukame tucifi burut bade isinaha. mini ama akū oho amala. bi tofohon se de. amba cooha dosire de. buranidun cungbagasi burut ci. meni ület haha jui juwe sargan jui juwe be durifi badakšan de gamafi hojomnidzar de buhe. ede ület sargan jui tubsin be minde sargan obume buhe. amala hojomnidzar. meni eigen sargan be ukaki sere gisun be donjifi. bi sargan be gaifi. badakšan ci hündus de ukame genefi. hündus i dalaha niyalma midzarab bek be dahalame. juwe aniya tehe. hündus i ba badakšan ci sindalabuhangge duin inenggi on bi. badakšan i wargi amargi ergide bi. hündus i urse usin tarime banjimbi. morin komso honin labdu. amala aiaugan i dalaha niyalma aihametša ini fejergi šabsang bek be takūrafi. hündus de jifi morin ulha jeku i jergi alban gaire de. midzarab i bisire ulha. meni eigen sargan be suwaliyame aiaugan i šabsang bek de bufi gamabuha. bi šabsang ni jakade juwe aniya ninggun biya takūšabuha. aiaugan i ba hündus i wargi julergi ergide be. hündus ci sindalabuhangge juwan juwe inenggi on bi. aiaugan i niyalma labdu. gisun bardanggi tabcilara durire de amuran. morin komso honin labdu. inu usin tarire banjimbi. jai lahur i ba onco halhun. aiaugan i dergi julergi ergide bi. nukteme yabuci susai inenggi isinjici ombi. aiaugan i niyalma aniyadari lahur i bade tuveri hetumbume genembi meni eigen sargan šabsang be dahame geneche bihe. sirame aniya niyengniyeri forgon de aiaugan i niyalma amasi jidere de bi sargan be gaifi ukame jailafi. lahur bade tutaifi. juwe biya giohošome yabuha. tede lahur ci kesimir de geneche. kesimir i dalaha niyalmai gebu nurtangha. tubai urse usin tarime banjimbi. morin ulha labdu akū bicibe. fejergi urse banjishün. bi uthai kesimir i bade tehe. kasigar i hūdai hoise niasbek de nikeme sunja aniya funceme tehe. kesimir i ba. lahur i dergi amargi ergide bi. juwan emu inenggi on. bi kesimir de bisire de hūdai hoise ci. amba enduringge ejen. jun gar hoise i gubci ba be yooni necihiyeme toktobufi. meni ület se teisu teisu bahafi jirgame sebjeleme baimbi shebe donjifi. bi mini sargan. sargan jui be gaifi. majige kunesun hüwaitafi. dergi amargi baru nadan inenggi yabufi. tubet i bade isinafi. meni ili i ület se. yarkiyān [sic] i jirgame sebjeleme banjire be tengkime saha ofi. tubet i dalaha niyalma yalbu de baifi. yalbu minde emu morin. juwan funcere inenggi kunesun i ufu bufi. bi mini sargan tubsin. sargan jui jinat be gaifi. ebsi baime jihe. jugūn de hūdai hoise abdurman sebe ucarafi cembe dahalame sasa yerkiyang de isinaha.] TT 35.06.xx. MaLFZZ 2379-026.2; 089-1979.

⁷⁹ Хэд хэдэн аман өчгөөс үзвэл, Мүндүбаярын өвгө эцэг Данжиндунбай нь Цэвээнравданы дүү байжээ. Цэвээнравдан түүнтэй муу харилцаатай тул түүнийг Асан хэмээх хүүгийнх нь хамт Аксуд илгээж суулгажээ. Тэнд Асаны хүү Мүндүбаяр төрөв. Цэвээнравдан Данжиндунбай хоёр

түүнийг аван Илим хүрч, Шара Күбүн хэмээн хиргис хүүхэнд өргүүлсэн нь өөрийн хүү шиг өсгөжээ. Тэр өөрийгөө Шара Күбүний хүү гэж бодож өссөн бөгөөд зөвхөн хиргисээр л ярьж ойрад хэлээ мартсан байв. Шар Күбүн болон түүний хоёр хүү нь нас барсны сүүлээр тэр Байн орчим амьдрах уйгур хүний гэрийн зарц болжээ⁸⁰. Тэнгэрийн тэтгэсэн хаан түүнийг Чингийн эсрэг бослогын тулгуур болохоос сэрэмжлэн хатуу харуул хамгаалалтын дор Бээжинд нэн даруй хүргэхийг тушаав.

Мүндүбаярын Бээжинд ирсэний дараа хэрхсэн нь тодорхой биш ч түүний түүх нь Зүүнгар дахь ойрадуудын угсаатны ухамсрын хувиралтыг харуулж байна. Чингийн засагт аюул учруулж мэдэхүйц Зүүнгарын хуучин удирдагчийн удам байсан учраас л Мүндүбаярын түүх бидэнд уламжилж иржээ. Түүнээс гадна цөөн хэдэн тохиолдол баримтад тохиолдлоор тэмдэглэгдэж үлдсэнээс бид Чин-Зүүнгарын дайны эцсээр хэсэг ойрадууд нутгийн хүн амд ууссан үйл явцыг олж мэдэж болно. Жишээлбэл, Бохолдай гэгч Зүүнгарын ойрад хүү Чингийн цэрэгт олзлогдоод Ма Илай гэгч худалдаачны зарц болсон бөгөөд мань худалдаачин түүнд сайхан хандаж, хүү шигээ өсгөжээ. Тэгээд түүний цайны худалдаанд туслан явсаар Бохолдай эзнийхээ овгийг авч өөрийгөө Ма Фу гэж болсон аж. Дараах өчгийг үзмүү:

“Ма Фу хэмээх нэгэн хүн монголоор өчсөн нь, Ма Фу би угаас Хэрээд отогийн өөлд. Нэр Бохолдай. Хорин нэгдүгээр он Жултусын газраас эзний солон цэрэгт олзлогдож Пижанд бүхий худалдааны иргэн Ма Илайд худалдагдан өгтөв. Пижанд худалдаалан явсан бөлгөө. Илим албаны цай хүргэхэд цмө худалдааны иргэний тэмээг үнэлэн илгээх тул Ма Илай түүний гурван тэмээг надад тушааж цай ачин энд хүрч ирэв. Миний ах өөлд цэрэг Баянд учирж харилцан танив. Иргэн Ма Илай намайг хэдүй өршөөн тэжээв, түүнээс хагацахыг төвдөхгүй авч, бас миний төрсөн ах Баян намайг таниж байн байн уйлж намайг тавихгүй. Бохолдай миний санаанд би энд хоцорвоос олж яс мах

хоёул нас барсны сүүлээр Галданцэрэн Асаныг Илим бага хүү Мүндүбаярын хамт дуудаж ирүүлжээ. Асан болон түүний эрэгтэй ах дүүс Даваачтай хийсэн тэмцэлд алагдсан бөгөөд бага настай байсан Мүндүбаяр л амь үлдэв. Асаны эгч Ламцэрэн Мүндүбаяр болон гучин хүн аван Бай хотноо зугтан очжээ. Хожа Жихан тэдний ихэнхийг нь алж хэдэн хөвгүүдийг уйгур худалдаачдад боол болгон худалдсанаас Мүндүбаярыг эзэн нь түүний тэжээсэн эх Шара Күбүнд худалдсан байна. Хаймин, ТТ 27.02.07. MaLFZZ 1926-023; 062-0882.

⁸⁰ Энэ түүхийг Хаймин, ТТ 27.02.07. MaLFZZ 1926-023; 062-0882. Айлтгалд тэмдэглэгдсэн хэд хэдэн өчгийг нийлүүлэн бичив. Энэ айлтгалд өөр ч тодорхой зүйл нилээд тэмдэглэгдсэн.

нийлвээс болмуй. Мөн хэвээр эзний албат тул бус өөлд нарын адил хүчин өгөн явбаас болмой⁸¹.

Миншүй түүний эзэн Ма Илай зөвшөөрсөн тохиолдолд л Ма Фу хэмээх Бохолдай Илид үлдэж болох юм хэмээн шийдэж Пижанд хэргийг тодорхойлсон бичиг илгээсэн Ма Илай Бохолдайг Илид ахынхаа дэргэд үлдэхийг зөвшөөрчээ. Ойрад боолынх нь оронд Ма Илайд долоон лан мөнгөн төлбөр олгосон байна. Боол болсон олон ойрад хүмүүс шинэ нэр устай болсон тул бидний анхааралд өртөж чадахгүй нь мэдээж. Ма Фу/Бохолдай эсвэл Тогтоши/Мүндүбаярын явдал нь ховор тохиолдол байв уу, эсвэл албан бичигт ховорхон тэмдэглэгдсэн ердийн зүйл байв уу, гэдгийг хариулахад нилээд төвөгтэй юм. Миний олсон зарим баримтанд олон ойрад хүмүүс, ялангуяа уйгуруудтай хамт сууж байгсад нь өөрийн угсаатны ухамсрыг гээсэн байсныг бичсэн байв. Жишээ нь, Чингийнхэн уйгур нараас ойрадуудыг мөнгөн төлбөрөөр худалдан авч байх цагт Юнгүй нар мөнгөн төлбөрөөр чөлөөлөгдөхийг хүсээгүй ойрадуудыг, нэгэнт уйгурын занг сурч тэдэнд уусах тул Уйгур нутагт үлдээхийг гуйн өргөжээ⁸². Алтышаараас худалдан авч ойрад эрчүүлтэй гэр бүл болгохоор явуулсан ойрад эмэгтэйчүүдийн дунд таван бүсгүй нь багаас уйгур нарын дунд суусаар ойрад хэлээ мартаж уйгурт ууссан байсан тул тэднийг ойрадын оронд Илид сууж байсан уйгур нарт эхнэр болгон өгсөн байна⁸³.

Үүнтэй төстэй үйл явц хасагуудын дунд сууж байсан ойрад эмэгтэйчүүдэд бас тохиолдсон бөгөөд хасагууд тэднээс эхнэр болгон авах хүсэлтэй хэдий ч тэд нь харин оргож босон Чинд дагаар орж байжээ. Энэ явдлыг таслан зогсоохын тулд зарим хасаг нар тэдний эрчүүдийг нь алж оргож босохоос сэрэмжилсэн аж. Тэднээс төрсөн хүүхдүүд нь хасаг үндэсний ухамсартай болж өснө гэж тооцсон байна. Жишээ нь, Жамба хэмээх нэнг ойрад боол хасагууд бүх ойрад эрчүүдийг алж эмсийг нь эзлэнэ хэмээн хэлэлцэхийг сонсоод гэр бүлээ аван зугтаж Чинд дагаар оржээ⁸⁴. Хасаг Хара Тулуши түүний овгийнхон

⁸¹ [ma fu sere emu niyalma monggorome alarangge. ma fu bi daci keret otok i ület gebu boholdai. orin emuci aniya jultus baci. ejen i solon cooha de oljilabufi. pijan de bisire hūdai irgen ma yilai de uncame bufi. pijan de hūdašame yabumbihe. ili de alban i cai benjibure de. gemu hūdai irgen i temen be turifi. benjibume ofi. ma yilai ini ilan temen be minde afabufi. cai acifi. ubade isinjiha. mini ahūn ület cooha bayan be ucarafi ishunde takaha. irgen ma yilai mimbe udu gosime ujihā. inci fakcara be jenderakū bicibe. damu mini banjihā ahūn bayan. ne mimbe takafi. emdubei songgome mimbe sindarakū. boholdai mini gūinde. bi ubade tutaci. bahafi giranggi yali acabuci ombime. inu an i ejen i albatu ofi. gūwa ület sei adali hūsun bume yabuci ombi.] Миншүй, ТТ 29.03.09. MaLFZZ 2079-028; 070-1281.

⁸² Юнгүй, ТТ 27.03.03. MaLFZZ 1932-019; 062-1850. Манжаар бичсэн нь дараах мэт. [goidaha manggi. ini cisui hoise i tacin de icebufi.]

⁸³ [ne hoise tacin de dosifi. ület i gisun fuhali bahanarakū.] Миншүй, ТТ 29.02.25. MaLFZZ 2076-010; 070-0704.

⁸⁴ Юн Үй, ТТ 25.04.06. MaLFZZ 1817-008; 056-1739

эмс хүүхдээ аван оргож босохоос сэрэмжлэн бүх ойрад эрэгтэйчүүдийг алах гэж байсныг харин Чингийн түшмэдэд худалдаж тэднээс оронд нь торго авсан байна⁸⁵.

8. Ойрад, хасагууд болон Зүүнгар дахь Чингийн угсаатны бодлого

Дээр эш татсан угсаатны ухамсрын хувиралтын жишээ нь Чингийн түшмэдийн хувьд төдийлөн гайхмаар зүйл байсангүй нь Чингийн төр Зүүнгар дахь угсаатны ухамсрыг тогтворгүй өөрчлөгдөж хувирдаг юм гэж үзэж байсантай холбоотой. Үндэс угсааны талаарх энэ ойлголт нь Зүүнгар дахь ойрад, хасагуудын хувьд хэрэгжүүлсэн тэдний бодлогыг тодорхойлсон юм. Зүүнгарын алтай язгуурын ард түмний угсаатны ухамсрыг Чингийн төр *giranggi* (яс) ба *banin/tacin* (байдал/суртал) гэсэн харилцан өөр ухагдахуунаар хуваан үзэж байв. *giranggi* хэмээх манж үг нь яс гэсэн үг бөгөөд удам угсаа уг язгууртай холбогдоно. *Giranggi* бол төрөлх зүйл өөрчлөгдөхгүй. *Tacin* гэдэг нь суртал, сургаал бөгөөд шашин буюу хэлтэй холбоотой харин *banin* гэдэг нь овор байдал гэсэн үг бөгөөд уг хүний ёс суртахуунтай холбогдоно. *Giranggi*-гаас ялгаатай *tacin* болон *banin* нь өөрчлөгдөж болно⁸⁶. Чингийн түшмэдийн хувьд ямарваа нэг хүний *giranggi* буюу яснаас илүү *banin/tacin* буюу байдал суртал нь чухал байжээ⁸⁷.

Жишээ болгон ойрадын дунд өссөн хоёр хасагийн тухай авч үзье. Тэд хоёулаа Чинд дагаар орж ойрад төрөл саднаа олох гэсэн бөгөөд нэг нь Баяхар хэмээгч, “Миний бие хасаг боловч багаас өөлдийн газарт аж суун эр болсон.

⁸⁵ Агуй, ТТ 27.01.18. MaLFZZ 1922-030; 062-0308. Хасагууд ойрадын эрчүүдийг нь алж эмсийг нь авах гэсэн өөр нэг оролдлогын тухай: [айлтгалын нэргүй], ТТ 30.01.29. MaLFZZ 2125-023; 072-3538.

⁸⁶ *giranggi* хэмээх ухагдахуун нь монголын *yasu* гэдэг үгтэй холбоотой болов уу. Хэдийгээр баталж чадахгүй ч гэсэн *banin* гэдгийг би хятад ухагдахуун гэж бодож байна. “Энэ зэргийн өөлд нар, амьдрах газар олсон хойно дараа дараагаар богд эзний хишгийг шүтэн тэдний угийн муу суртлыг халан” [ere jergi ület se. banjire ba baha manggi. teisu teisu enduringge ejen i kesi be hukšeme. ceni da ehe banin halafi.] гэсэн энэ эшлэл Күнзийн сургаалын санаатай яг сайхан нийлнэ. Антай, ТТ 25.09.10. MaLFZZ 1840-058; 057-3109. *Tacin* хэмээх үг өнөөгийн бидний шашин болоод хэлийг дотор нь оруулж үздэг “соёл” гэдэгтэй холбогдоно. Тэнгэрийн тэтгэсэн хаан манж нарыг Хятадын соёлд автаж байгааг “Хятад сурталд орох” [nikan tacin de dosimbi] хэмээн нилээд зэмлэж байжээ. Тийм учраас энэ *tacin* гэдэг үг ойрад хасаг нарын шинэ соёлын ухамсартай болсныг илэрхийлэхэд хэрэглэгдсэн байна. Заримдаа *banin/tacin* –г *mujilen* буюу *günin mujilen* санаа, зүрх сэтгэл гэсэн үгтэй эсрэгцүүлэн хэрэглэсэн тохиолдол байна. “Санаа сэтгэл нь басхүү өөлд боловч байдал суртал нь нэгэнт хасагийн адил болсон” [günin mujilen kemuni ület bicibe. banin tacin emgeri hasak i adali oho.] Жунбоо, ТТ 28.10.22. MaLFZZ 2058-002. 069-0291.

⁸⁷ Энэ зарчим харин оросуудын хувьд үйлчилсэнгүй шиг. Жишээ нь Иван хэмээх орос найман настайдаа хасагт олзлогдож тэдний дунд хорь гаруй жил амьдарсны эцэст зугтаж Илим хүрээд Чинд дагажээ. Мэдүүлгээ амаар хасаг хэлээр өгчээ. Хасагийн дунд ихэнх амьдралаа өнгөрүүлсэн хасагаар ярьдаг түүнийг орос хэмээн үзэж Бээжинд илгээж шийтгэхээр тогтсон байна. Чингийн түшмэл Антай түүний тухай: “Иван хэдий хасагийн газарт хорь илүү жил суусан хэмээвч бас л орос”. [iban udu hasak i bade orin funcere aliya tehe secibe. jiduji oros.] Антай, ТТ 36.02.12. MaLFZZ 2404-046; 091-1453.

Миний эм, хадам эцэг эхийн ах дүү цөм өөлд эдүгээ Илнд бүхий учирт би дураар нэг газарт суусугай” хэмээн өчжээ.⁸⁸ Нөгөө нэг Чуйдаш хэмээгч хүүхний эх нь ойрад хүн байсан бөгөөд бас багаасаа ойрадуудын дунд өссөн гээд Илнд байгаа төрөл саднаа олох хэмээсэн байна. Тэдний хүсэлтийг шийдвэрлэх явцдаа Чингийн тал тэднийг хэрхэн үзэж байгаа талаар Миншүйгийн бичсэнийг сийрүүлбэл:

“Баяхар Чуйдаш хэдий цөм хасаг ястай боловч бас эд багаас цөм өөлд газарт суусан хүн. Эзний хишгийг хүртсүгэй хэмээн эрэн ирж санаа чин хэмээмой. Өөлдийн дотор тэдний садан төрөл байна. Хуучин өөлд нар тэдний гарлыг мэдэхийг даган боолчууд эзэнд эрэн ирсэн албатыг бүгд адил өршөөхийг үзүүлэн Баяхар Чуйдашийг өөлд суманд оруулан суулгажээ”⁸⁹.

Уг нь бол хасагуудыг ойрадын адил дагаар орж Илнд суухыг зөвшөөрдөггүй байсан бөгөөд энэ тохиолдолд Чингийнхэн тэднийг хэдийгээр хасаг giranggi буюу ястай ч ойрадууд хэмээн үзсэн учраас онцгойлон үзжээ.

Өөр нэг жишээ дурдвал, хасаг Жанкишийн хэрэг юм. Жанкиши нь таван настай ойрадад олзлогдсон хасаг ястай хүн бөгөөд Зүүнгарын улс мөхөхөд Хасагт очиж суужээ. Чингийн түшмэл Нусан хэмээгч Хасагт элчин болон явахад Жанкиши түүний хөтөч орчуулагч болж явахдаа Хасагаас оргож очих санаатайгаа “Жанкиши би ойрад зан журамд сурсан хүн номгүй хасагуудын дунд байж чадахгүй” хэмээн ярьсан аж. Тэгээд удалгүй бас өөр нэг хасаг гаралтай ойрад Эсэргэба хэмээгчтэй цуг оргон ирж дагав. Агуй тэр хоёрыг хэдий хасаг giranggi ястай ч ойрадын адил хүлээн авчээ. Агуйн айлтгалд, “Жанкиши, Эсэргэба хоёр хүн хэрэв жинхэнэ хасаг хүн болвоос энд агуулан суулгахгүй бөлгөө. Басхүү эд багаас өөлдийн газарт сууж ирсэн өөлд нараас огт өөр үгүй” хэмээсэн байдаг⁹⁰.

Жанкиши мэтийн хасаг ойрад хэлийг хоёуланг нь мэдэх хүмүүс Хасаг болон Чингийн харилцаанд зуучлагчийн үүргийг гүйцэтгэжээ. Тэдгээр нь зөвхөн Зүүнгарыг эзэлсэн Чингийн нөлөө байсангүй, хэдэн зууны турш бие биеийгээ довтолгон хүн олзолж явсан Хасаг Ойрад хоёрын дунд иймэрхүү

⁸⁸ [mini beye hasak bicibe. ajige ci ület i bade banjihai hahardaha. mini sargan amaka emeke sargan i ahūta deote gemu ület. ne ili de bisire turgunde. bi cihanggai emu bade banjiki seme.] Миншүй, ТТ 28.04.10. MaLFZZ 2025-012: 067-0350.

⁸⁹ [bayahar. cuidasi. udu gemu hasak giranggi bicibe. damu ese ajige ci gemu ület bade banjihai niyalma. ejen i kesi be aliki seme baime tucike gūnin hing sembi. ület i dorgi. ini niyaman hūnchih bimbime. fe ület se inu erei sekiyen be sara be dahame. ahasi ejen de baime jihe albatu be yooni adali gosire be tuwabume. bayahar. cuidasi be ület niru de dosimbufi tebuhebi.] дээр эшилсэн айлтгал.

⁹⁰ [jangkiši. esergeba juwe niyalma. aika jingkini hasak oci. ubade bibume banjinarakū bihe. damu ese ajige ci ület i bade banjihai jihe. ület seci umai encu akū.] Агуй, ТТ 26.12.04. MaLFZZ 1914-020: 061-2563.

холимог угсаатны хүмүүс Хасаг Ойрад хоёуланд нь гарч ирсэн нь дамжиггүй юм. Төгсгөлд нь би ийм холимог ухамсартай хүмүүс Зүүнгар дахь Чингийн ноёрхлын эхний арван жилд Хасаг Чингийн төр хоёрын дунд соёлын гүүр болсныг товчхон өгүүлье.

Дүгнэлт: Угсаатны холимог ухамсар ба Ойрад-Хасагийн харилцаа

Энэ өгүүлэлд 1757-1771 оны хооронд ойрадуудад хандаж явуулсан болон ойрадуудын удаан жилийн дайсан хасагуудтай харилцах Чингийн бодлогын боловсруулалтыг шинжилж үзсэн болно. Үүнд би ойрадуудын Чин болон Хасагийн хооронд соёлын зуучлалын чухал үүрэг гүйцэтгэснийг ер ярьсангүй. Ойрад болон хасагууд нь хэдэн зууны турш ойр дотно харилцаж хоёр талд холимог гаралтай улсууд их байсан зэргээс үүдэн хасагууд ойрадаар ярьж, харилцаж чаддаг байсан бөгөөд олон ойрадууд хасаг хэл мэддэг байв. Чин-Хасагийн харилцааны эхний арван таван жилд ойрад хэл Зүүнгарын хуучин хил орчмын газар *lingua franca* болж байсан агаад Чин болон Хасагийн хоорондох бичиг харилцааны ихэнх нь ойрад үсгээр бичигдсэн байв⁹¹. Чингийн харуулын цэргийг ойрад орчуулагчид үргэлж даган явдаг байсан бөгөөд хасаг ойрадын хоорондох орчуулгыг туслалцах үүрэгтэй байжээ. Чингийн Зүүнгар дахь ноёрхлын эхний жилүүдийн хятад газар зүйн номд хүртэл ойрад хасаг нарын бичиг нэгэн адил хэмээн андуурч байв. Хасагуудын дунд удаан суусан ойрад нар үе үе Чингийн түшмэдэд нууц мэдээ дамжуулдаг, газар орноо сайтар мэдэх учир Чингийн Зүүнгар дахь эргүүл харуулын цэргийн хөтөч болж явсан тухай дараа тусгайлан өгүүлнэ.

Abstract: This paper has presented Qing policy toward the Oirats from 1757 to 1771, and has analyzed the implications this policy had for Qing relations with the Oirats' longtime nemesis, the Kazakhs. What I have not discussed, however, is that the Oirats served a vital role as cultural intermediaries between the Qing and the Kazakhs. Because the Oirats and Kazakhs had lived in close contact for over a century, and because there were so many people of mixed-ancestry on both sides, the Kazakhs were able to communicate in Oirat, and many Oirats could speak Kazakh. During the first fifteen years of Qing-Kazakh relations, Oirat served as the *lingua franca* of the Jungar borderlands, and most written diplomatic correspondence between the Qing and the Kazakhs was carried out in Oirat script

⁹¹ Энэ ойрад үсгийн баримтуудаас зарим нэг нь бидний үед хүрч ирснийг манж айлтгалуудын хамтаар хадгалж байна. Ийм ойрадын тод үсгийн баримт нь ихэвчлэн манж орчуулгатай байдаг бөгөөд ойрад эх болон манж орчуулга нь хоёулаа Бээжинд илгээгддэг байжээ. Ямар шалтгаанаар юм бүү мэд ойрад эх бичгүүд нь үрэгдэж Чин Хасагийн харилцаанд холбогдох тэдгээр ойрад баримтуудын манж орчуулга үлдэж хоцорсон байна. Иймэрхүү манж орчуулгыг ойрад үсгийн баримтаас орчуулсан байна гэдгийг тодорхой мэдэж болохоор онцлогтой байдаг. Хожим нь хасагууд албан бичгээ хасаг хэлээр араб үсгийг ашиглан бичиж илгээх болжээ.

documents. Oirat translators always accompanied Qing patrols to facilitate translation between Kazakhs and Oirats. In fact, Chinese language gazetteers from the first decades of Qing rule in Jungaria mistakenly assert that the written script of the Oirats and Kazakhs is the same. Oirats who had lived for a long time among the Kazakhs also served the Qing as spies, periodically supplying Qing officials with secret information on the Kazakhs. The Oirats also served as guides to Qing patrols in Jungaria, since they were far more familiar with the local geography than Qing troops.

Англи хэлнээс орчуулсан: Цонгоол Б.Нацагдорж

Хавсралт: Тэнгэрийн тэтгэсний 24 болон 25-р онд Хасагаас дагаж ирсэн ойрадууд.

Нэр	Нас	Хүйс	Дагасан он	Олзлогдсон он	Олзлогд- оход хэдэн настай байсан	Олзон байсан жил	Уг нутаг болон отог	Эшлэл	Тайлбар
Лобжиа		Эр	ТТ 24	ТТ 21		3	Хэрээд отог	MaLFZZ 053-2265 QL24-06-03	Энэ бол Хасагийн нутгаас ойрад хүн босч ирж Чинд дагаар ирснийг тэмдэглэсэн анхны тохиолдол болно.
Лобжиа-гийн эх		Эм	ТТ 24	ТТ 21		3	Мөн адил	Мөн адил	
Лобжиа-гийн эхнэр		Эм	ТТ 24	ТТ 21		3	Мөн адил	Мөн адил	
Амтайхан		Эр	ТТ 24	ТТ 21		3	Мөн адил	Мөн адил	
Баян		Эр	ТТ 24	ТТ 21		3	Мөн адил	Мөн адил	Лобжиагийн бел
Шара		Эр	ТТ 24	ТТ 21		3	Мөн адил	Мөн адил	Лобжиагийн бел
Цэгэр		Эр	ТТ 24	ТТ 23		1	Бүхүүнүд отог зайсан Захчин	MaLFZZ 053- 3392 ТТ 24-илүү06.19	Эхлээд Амарсанаад ТТ 20 онд баригдсан. Хожим Хасагт ТТ 23 онд олзлогдсон.
Мажан		Эм	ТТ 24				Мөн адил	Мөн адил	Цэгэрийн үеэл. Түүнтэй Хасагт таарч хамтаар Чинд дагасан.
Надар		Эр	ТТ 24	ТТ 23		3	Уг гарал нь хиргис 6 настайдаа мянгал отогийн тайж Сэбтэндашид олзлогдсон.	Мөн адил	Цэгэр Мажан хоёрын хамт оргосон.

Даху		Эр	ТТ 25	ТТ 22		3		MaLFZZ 055-2846 ТТ 25.01.20	
Дахугийн эхнэр		Эм	ТТ 25	ТТ 22		3		Мөн адил	
Мэнд		Эр	ТТ 25	ТТ 22		3		Мөн адил	
Мэндийн эх		Эм	ТТ 25	ТТ 22		3		Мөн адил	
Жимба	26	Эр	ТТ 25	ТТ 20	21	5		Мамуд зайсан	MaLFZZ 056-1739 ТТ 25.0406
Молон	28	Эр	ТТ 25	ТТ 20	23	5		Мөн адил	Мөн адил
Бэбху	15	Эр	ТТ 25	ТТ 20	10	5		Мөн адил	Мөн адил
Цэрэн	50	Эм	ТТ 25	ТТ 20	45	5		Мөн адил	Мөн адил
Хунгур	24	Эм	ТТ 25	ТТ 20	19	5		Мөн адил	Мөн адил
Дожин	52	Эр	ТТ 25	ТТ 15	42	10		Дөрвөдийн Цэрэн тайж	MaLFZZ 056-2881 ТТ 25.05.13
Тэкин	51	Эм	ТТ 25	ТТ 15	41	10		Мөн адил	Мөн адил
Тас	18	Эр	ТТ 25	ТТ 15	8	10		Мөн адил	Мөн адил
Баяа	26	Эр	ТТ 25	ТТ 21	22	4		Даваач/ Тарвагатай	Мөн адил
Шара	22	Эр	ТТ 25	ТТ 23	19	2		Дашдаваа/ Шарбэл	Мөн адил
Шурган	18	Эр	ТТ 25	Барс жил		3		Ангидай / Шарбэл	MaLFZZ 057-0341 ТТ 25.06.02
Акжул	27	Эр	ТТ 25	Барс жил		3		Сэтгэж жас, мусульман гаралтай ч	Мөн адил

Уг нутаг Борталыг нь барс
жил уулгалсан ба Шарбэл
рүү Ангидайн албагуудтай

							багаасаа ойрадын дунд өссөн		хамт зугтаж Шарбэлд Шурганыг олзлогдсон жил Хасагт баригджээ.
Бурун	28	Эр	ТТ 25	ТТ 20	23	5	Зайсан Цүхидаш / Шарбэл	MaLFZZ 057-1035 ТТ 25.07.06	
Төгс	19	Эм	ТТ 25	ТТ 20	14	5	Мөн адил	Мөн адил	Бурунгийн эхнэр
Бурун, Төгсийн нялх хүүхэд			ТТ 25						
Манни	27	Эр	ТТ 25	ТТ 20	22	5	Мөн адил	Мөн адил	Бурунгийн дүү
Мэндэш	21	Эм	ТТ 25	ТТ 20	16	5	Мөн адил	Мөн адил	Маннигийн эхнэр
Манни, Мэн- дэшийн хүү		Эр	ТТ 25				Мөн адил	Мөн адил	
Санжи	24	Эр	ТТ 25	ТТ 20	19	5	Мөн адил	Мөн адил	
Бичихан	30	Эм	ТТ 25	ТТ 20	25	5	Мөн адил	Мөн адил	Санжийн эхнэр
Урианхай	19	Эр	ТТ 25	ТТ 20	14	5	Мөн адил	Мөн адил	
Жаргал	40	Эр	ТТ 25	ТТ 22	37	3	Зайсан Даш /Алтай	Мөн адил	
Бүрэн	38	Эм	ТТ 25	ТТ 22	35	3	Мөн адил	Мөн адил	Жаргалын эхнэр
Цэвэг	19	Эр	ТТ 25	ТТ 22	16	3	Мөн адил	Мөн адил	
Батур	26	Эр	ТТ 25	ТТ 21	22	4	Зайсан Хэрбур/Или	Мөн адил	
Модор	23	Эм	ТТ 25	ТТ 21	19	4	Мөн адил	Мөн адил	Батурын эхнэр
Гүмү	20	Эр	ТТ 25	ТТ 21	16	4	Мөн адил	Мөн адил	Батурын дүү
Мамуд	42	Эр	ТТ 25	ТТ 22	39	3	Хурман Даймирэн / Бор тал	Мөн адил	
Обид	29	Эм	ТТ 25	ТТ 22	26	3	Мөн адил	Мөн адил	Мамудын эхнэр
Сохан	7	Эр	ТТ 25	ТТ 22	4	3	Мөн адил	Мөн адил	Мамудын том хүү

Хуламбай	2	Эм	ТТ 25	ТТ 22	Төрөөгүй байсан	Мөн адил	Мөн адил	
Самтан		Эр	ТТ 25	ТТ 22		3	MaLFZZ 057-1653 ТТ 25.07.02	Мөн адил
Чойрог		Эм	ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	Самтангийн эхнэр
Үлэмж		Эм	ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	
Чомэд			ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	Үлэмжийн хүүхэд
Сэбэг		Эр	ТТ 25	ТТ 21		4	Шарбэл нутаг	
Баба		Эр	ТТ 25	ТТ 19		6	Тарвагачин отог	
Өлзий		Эр	ТТ 25	ТТ 22		3		
Батеуурь		Эр	ТТ 25	ТТ 15		10	Долод	
Эсүкү		Эр	ТТ 25	ТТ 15		10	Төмөрчин урад	
Бэлэг нар			ТТ 25	ТТ 19		6	MaLFZZ 057-1545 ТТ 25.07.26	Энэ айлтгалд дурдсан ойрадуудаас 14 нь эрэгтэй, 2 нь эмэгтэй байжээ.
Үчэрэ нар			ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	
Аюуш			ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	
Тариачин нар			ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	
Дашжав		Эр	ТТ 25				MaLFZZ 057-2536 ТТ 25.08.03	
Долог		Эр	ТТ 25	ТТ 15		10	Долод отог	
Дологийн эхнэр		Эм	ТТ 25	ТТ 15		10	Мөн адил	
Дологийн дүү		Эр	ТТ 25	ТТ 15		10	Мөн адил	

Хунхо	Эр	ТТ 25	ТТ 22		3	Күбүн ноёд отог	Мөн адил	Мөн адил	
Хунхогийн эхнэр	Эм	ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Бэмбэ	Эр	ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Талдаш	Эр	ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Дондог	Эр	ТТ 25	ТТ 21		4	Их Хүрээ жас отог	Мөн адил	Мөн адил	
Дэлгэр	Эр	ТТ 25	ТТ 17		8	Хөтөнчнэр отог	Мөн адил	Мөн адил	
Дэлгэрийн эх	Эм	ТТ 25	ТТ 17		8	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Дэлгэрийн хоёр дүү	Эр	ТТ 25	ТТ 17		8	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Дүлхигэр	Эр	ТТ 25	ТТ 17		8	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Чогжаба	Эр	ТТ 25	ТТ 17		8	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Хайрбижан	Эр	ТТ 25	ТТ 17		8	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Элхүн	Эр	ТТ 25	ТТ 17		8	Их мянган отог	Мөн адил	Мөн адил	
Цэрэн	Эр	ТТ 25	ТТ 17		8	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Борин	Эр	ТТ 25	ТТ 17		8	Мөн адил	Мөн адил	Мөн адил	
Нохой	Эр	ТТ 25	ТТ 22		3	Күбүн ноёд отог	MaLFZZ. 057-2740 ТТ 25.08.10	MaLFZZ. 057-2740 ТТ 25.08.10	
Нэмэх	Эм	ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	Мөн адил	Мөн адил	Нохойн эхнэр
Мама	Эр	ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	Мөн адил	Мөн адил	Нохойн дүү
Күбүн	Эр	ТТ 25	ТТ 22		3	Урад отог	Мөн адил	Мөн адил	
Эркэ	Эм	ТТ 25	ТТ 22		3	Мөн адил	Мөн адил	Мөн адил	Күбүний эхнэр
Тубул	Эр	ТТ 25	ТТ 22		3	Тарвагачин отог	Мөн адил	Мөн адил	
Амур	Эр	ТТ 25	ТТ 22		3	Шамбиллин жас	Мөн адил	Мөн адил	

Харикүбүн Монгос		Эр	ТТ 25	ТТ 20		5	Хойд	Мөн адил	Уг нь хиргис боловч ойрадад олзлогдож тэдний дунд өсчээ.
		Эр	ТТ 25	ТТ 20		5	Хойд	Мөн адил	
Харчин		Эр	ТТ 25					Мөн адил	
Орос		Эр	ТТ 25	ТТ 22		3	Бардамуд отог	Мөн адил	
Отон		Эр	ТТ 25	ТТ 20		5	Мөн адил	Мөн адил	
Гэжик		Эр	ТТ 25	ТТ 20		5	Мөн адил	Мөн адил	
Төмөр	36	Эр	ТТ 25	ТТ 19	30	6	Холбос отогийн албат	MaLFZZ 057- 2851 TT 25.08.19	
Тугтун		Эм	ТТ 25	ТТ 19		6	Мөн адил	Мөн адил	Төмөрийн эхнэр
Нэмэх	19	Эр	ТТ 25	ТТ 19	13	6	Мөн адил	Мөн адил	Төмөрийн дүү
Боди		Эр	ТТ 25	ТТ 19		6	Мөн адил	Мөн адил	Төмөрийн хүү
Алутчи	18	Эр	ТТ 25	ТТ 18	11	7	Кашгарын хотон авч Зүүнгарын Мянгад отогт харьяалаг-даж байв.	Мөн адил	
Даржиба		Эр	ТТ 25				Их шан	MaLFZZ 058- 0296 TT 25.09.19	Хасагаас оргоод ууланд гураван жил зурам барьж амь зуужээ.
Харакүбүн		Эр	ТТ 25	ТТ 22		3		Мөн адил	
Даба нар			ТТ 25	ТТ 22		3	Күбүн ноёд отог	Мөн адил	
Санж		Эр	ТТ 25	ТТ 22		3	Дулба жас	MaLFZZ 058- 0587 TT 25.09.26	
Хогон		Эр	ТТ 25	ТТ 22		3	Хөтөнчэр отог	Мөн адил	

Мөнх	Эр	ТТ 25	ТТ 22		3	Торгууд Баатар увш	Мөн адил	Мөнх хасагуудад олзлогдсон торгууд байжээ.
Мөр	Эр	ТТ 25	ТТ 20		5	Долоод отог / Шарбэл	MaLFZZ 058-1109 ТТ 25.10.08	
Цэвэг	Эр	ТТ 25	ТТ 20		5	Дөрвөд	Мөн адил	
Даваадаш	Эр	ТТ 25	ТТ 20		5	Харчин отог	Мөн адил	
Даш болон бусад	Эр	ТТ 25	ТТ 19		6		MaLFZZ 058-1245 ТТ 25.10.19	
Баяр	Эр	ТТ 25				Дулба жас	MaLFZZ 058- 1709 ТТ 25.10.21	
Гэцүн	Эр	ТТ 25				Күрэд отог	Мөн адил	
Буруд	Эр	ТТ 25				Мөн адил	Мөн адил	
Эрхэ	Эм	ТТ 25				Мөн адил	Мөн адил	Гэцүний дүү
Баянжаргал	Эр	ТТ 25				Мөн адил	Мөн адил	Бурудийн эхнэр
Охуй нар		ТТ 25					MaLFZZ 058- 2229 ТТ 25.11.05	
Орос нар		ТТ 25					Мөн адил	
Цэвэг	Эр	ТТ 25	ТТ 20		5	Бардамуд отог	MaLFZZ 058- 2734 ТТ 25.11.13	
Кэбэкэ	Эр	ТТ 25	ТТ 20		5	Күрэд отог	Мөн адил	
Чунжаба	Эр	ТТ 25	ТТ 20		5	Күбүн ноёд отог	Мөн адил	
Күкэ	Эр	ТТ 25	ТТ 20		5	Хойд	Мөн адил	
Шованкү	Эр	ТТ 25	ТТ 22		3	Урад отог	MaLFZZ 059- 0030 ТТ	

Өлзиймөнх	Эр	ТТ 25	ТТ 21				Мөн адил	25.12.10	
Айкэ Мүндү	Эр	ТТ 25	ТТ 21			4	Мөн адил	Мөн адил	Өлзиймөнхийн дүү
Носхай	Эр	ТТ 25				4	Мөн адил	Мөн адил	
Шархалтай	Эр	ТТ 25					Гарвагачин отогт сууж байсан.	Мөн адил	Уг нь Кашгарын хотон тул тийш нь илгээжээ.
Улаан	Эр	ТТ 25					Хадан отог	Мөн адил	
Хотон Бикэ	Эр	ТТ 25					Дөрвөд	Мөн адил	